

## ГАРЧИГ

- 2–3 Бодлогын нийтлэл
- 4–7 Зохицуулалтын мэдээ
- 8–9 Байр суурь
- 10–12 Тогтвортой санхүүжилт
- 13–14 Компанийн засаглал, комплайнс
- 15–16 Финтек ба регтек
- 17–23 Судлаачийн индэр
- 24–25 Зээлийн мэдээллийн сан гэж юу вэ?
- 26–27 Олон улсын зах зээлийн мэдээ
- 28 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

## ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БОЛОН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОХ ӨӨРЧЛӨЛТҮҮД



Сайн байна уу. Ярилцлагаа Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт батлагдсантай холбогдуулан түүний хэрэгцээ шаардлага болон зах зээд үзүүлэх цаашдын үр нөлөөний талаар эхлүүлье.

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль анх 1994 онд иргэдэд өмчийн хуваарилалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, зохицуулах, хөрөнгө оруулагч

болон үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, зах зээлийн дэд бүтцийг бий болгох зэрэг цоо шинэ зах зээлийн харилцааны тогтолцоог бий болгох зорилгоор батлагдаж байсан түүхтэй. Улмаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2002 оноос дагаж мөрдөн өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийг 2013 онд шинэчлэн баталж, түүнээс хойш нийтдээ 7 удаагийн нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байдаг.

Өнгөрсөн хугацаанд, нэн ялангуяа сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээл эрчимтэй хөгжин өөрчлөгдөж, олон төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээ бий болж, улмаар зах зээлийн үнэлгээ 11 их наяд гаруй төгрөгт хүрсэн ололт амжилтыг үзүүлээд байна.

Ийнхүү хөрөнгийн зах зээл дэх хурдацтай хөгжлийн өөрчлөлтийн улмаас шинэ санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх, хэрэглэхтэй холбогдсон харилцааг нэн даруй зохицуулж, холбогдох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, мөн төрийн бодлогын шинэчлэлийг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага бий болсон.

Түүнчлэн Үнэт цаасны зах зээлийн тухай хууль нь компанийн бонд гаргахтай холбоотойгоор бусад хууль журамтай цогц уялдаа холбоо, нийтэд санал болгон гаргах үйл ажиллагааны зохицуулалт дутмаг, биржийн бус зах зээл, үнэт цаасны эрх бүртгэлийн систем болон арилжааны төлбөр тооцооны эрх зүйн орчин тодорхой бус, үнэт цаас гаргагчийн компанийн засаглалын тогтолцоо, мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт сул байгаа зэрэг нь цаашид зах зээлийг тэлэх, хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэхэд зарим хүндрэлийг үүсгэж, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагыг үүсгээд байсан юм.



## ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

### ИТГЭЛЦЭЛ

Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэхэд иргэд, төрийн албан хаагчдын хамтын ажиллагаа, харилцан итгэлцэл ихээхэн ач холбогдолтой байдаг. Олон нийтийн таашаалд нийцсэн шийдвэрийг хэрэгжүүлэхэд хялбар байдаг бол тэдэнд таашаагдаагүй шийдвэрийг хэрэгжүүлэхийн тулд удирдагчид эхлээд итгэл олж авахад шаардлагатай засаглалын капитал бүрдүүлэх хэрэгтэй болдог. Иргэд хэрэв улс төрийн гол байгууллагуудад итгэдэг бол улс орны урт хугацааны эрх ашгийн төлөө гаргаж байгаа тэдэнд төдийлөн таашаагдаагүй шийдвэрийг ч дэмжихээс татгалздаггүй. Харин иргэд эдгээр байгуулалд итгэдэггүй бол хамтран ажиллахаас татгалзаж, хууль тогтоомжийг үл тоомсорлох явдал гардаг бөгөөд энэ нь засгийн газрын ажлын үр нөлөөг бууруулдаг. (Томасоли, 2007)



### TRANSPARENCY

Trust, the process by which government policies are carried out through the cooperation of citizens with public officials, is of fundamental importance for governance. While implementing popular decisions is easy, leaders need the governance capital that trust provides in order to carry out unpopular decisions. If major political institutions are deemed trustworthy, citizens are more likely to cooperate with unpopular decisions necessary for the long-term benefit of a society. If institutions are distrusted, citizens may refuse to cooperate or ignore laws and regulations, and the effectiveness of government is thereby reduced. (Tommasoli, 2007)

*Эх сурвалж: Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг*

## БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

### МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА: ШИНЭЧЛЭГДСЭН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ



Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (цаашид “ФАТФ” гэх) нь дэлхийн санхүүгийн системийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх (цаашид “МУТС/ҮОХЗДС” гэх) гэмт хэрэгт ашиглагдахаас хамгаалах бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газар хоорондын хараат бус байгууллага юм. Энэ хүрээнд стандарт тогтоох замаар улс орнуудын үндэсний хууль тогтоомж, зохицуулалтыг бэхжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Нийтдээ глобал сүлжээний 200 гаруй улс орон ФАТФ-ын стандартыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн.

ФАТФ-аас улс орнуудын МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх тогтолцоо, хариу арга хэмжээний чадавхыг үнэлэх хүрээнд Техникийн 40 Зөвлөмж, Үр дүнтэй байдлын 11 шууд хэрэгжилт гэсэн 2 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийж гүйцэтгэдэг ба харилцан үнэлгээний дэлгэрэнгүй тайланг гаргадаг. Үүнд, тухайн улс орон шаардлагатай хууль эрх зүйн орчноо бүрдүүлж, МУТСТ бодлогоо тодорхойлсон эсэх, мөн эрх бүхий байгууллагууд нь хангалттай нөөц бололцоотой, хувийн хэвшлийн байгууллагууд нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чадамжтай эсэх зэрэг асуудлуудыг тусгана.

Харилцан үнэлгээний үр дүн нь улс орны хувьд өндөр ач холбогдолтой байдаг. Үнэлгээ сайн гарснаар олон улсын тавцанд тухайн улсын санхүүгийн системийг найдвартай гэж үзэх бөгөөд эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлдөг. Нөгөөтээгүүр муу үнэлгээтэй гарснаар МУТС-тэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу “саарал жагсаалт”-д орох, бусад улс өөрийн санхүүгийн системийг хамгаалах хүрээнд бизнесийн харилцаагаа таслах, өндөр эрсдэлтэй гэж үзэн хатуу шаардлага, шалгуурыг тавих зэргээр урт хугацааны сөрөг нөлөөлөлтэй байдаг.

ФАТФ-аас хамгийн анхны харилцан үнэлгээг 1998 онд хийж байсан бол глобал сүлжээний улс орнуудыг үнэлэх 4 дэх шатны харилцан үнэлгээний процесс хэрэгжиж байна. Энэхүү шат 2025 онд дуусаж, 5 дахь шатны харилцан үнэлгээ эхлэх юм. МУТС гэмт хэргийг үйлдэх арга, хэрэгсэл нь техник, технологийн хэрэглээ, хувьсан өөрчлөгдөж буй нийгмийн хэрэгцээ, шаардлагаас үүдэн улам бүр боловсронгуй болж буй тул харилцан үнэлгээний шинэ шат бүрд үнэлгээний аргачлалыг шинэчилдэг. Тухайлбал, ФАТФ-аас улс орнуудын МУТСТ тогтолцоог зөвхөн Техникийн 40 Зөвлөмж буюу хууль эрх зүйн орчинд үндэслэн үнэлдэг байсан бол 2012 онд харилцан үнэлгээний аргачлалд өөрчлөлт орсноор МУТС

гэмт хэрэгтэй тэмцэж буй үр дүнтэй байдлыг мөн шалган үнэлдэг болсон.

Харилцан үнэлгээний нэг онцлог нь тус үнэлгээг улс орнуудын төлөөллөөс бүрдсэн шинжээчдийн баг хийж гүйцэтгэдэг тул үнэлгээний чанар, нэгдсэн байдлыг хангахад дээрх аргачлалыг гарын авлага байдлаар ашиглаж байна. Тухайлбал, Монгол Улсын 2017 оны харилцан үнэлгээг 4 дэх шатны харилцан үнэлгээний аргачлалыг ашиглан Оросын Холбооны Улс, Малайз, Хятад, Макао, Шри Ланка, Индонез зэрэг улс орны төлөөллөөс бүрдсэн үнэлгээчдийн баг хийж гүйцэтгэсэн.


5 дугаар шатны харилцан үнэлгээнд улс орнуудын орох дарааллыг 1) Тухайн улсын харилцан үнэлгээнд сүүлд орсон хугацаа 2) МУТС эрсдэлийн түвшин 3) Эдийн засаг болон санхүүгийн салбарын хэмжээ гэсэн 3 үндсэн хүчин зүйл дээр үндэслэн тогтоох юм. Эдгээр хүчин зүйлсийг харгалзсанаар харилцан үнэлгээ нь хоцрогдсон, өндөр эрсдэлтэй эсхүл нөлөө бүхий санхүүгийн салбартай улс орнуудыг нэн тэргүүнд үнэлэх нөхцөлийг бүрдүүлэх юм.

ФАТФ-аас өөрийн цахим хуудсанд урьдчилсан байдлаар 5 дахь харилцан үнэлгээнд хамрагдах улс орнуудын дарааллыг нийтлээд байгаа ба үнэлгээг хийж гүйцэтгэхэд ашиглагдах шинэчлэгдсэн үнэлгээний аргачлалыг эцэслэн батлахаар холбогдох олон улсын байгууллагууд, бүс нутгийн гишүүн байгууллагуудтай өндөр дээд хэмжээнд хэлэлцэж байна. Тус шинэчлэгдсэн аргачлалд орж буй томоохон өөрчлөлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

#### 5 дахь шатны харилцан үнэлгээний аргачлалд орсон гол өөрчлөлтүүд

- ◆ Дараагийн шатны харилцан үнэлгээ нь улс орнууд өөрсдийн хууль, дүрэм журмыг үр дүнтэй хэрэгжүүлж, ашиглаж байгаа эсэхэд илүүтэй анхаарах юм.
- ◆ Үнэлгээчдийн баг нь бага эрсдэлтэй эсхүл мөрдөн байцаах, ял тогтооход хялбар нөхцөл байдлаас илүүтэй улс орны МУТС өндөр эрсдэлтэй нөхцөлд анхаарал хандуулах болно. Ингэснээр эрсдэлийг ойлгох, бууруулах тогтолцоо бүрдсэн эсэхийг тогтоох боломжтой болох юм.
- ◆ Энэхүү шинэ аргачлалаар санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбарын МУТС үр дүнтэй байдлыг тус тусад нь үнэлэх юм. Энэ нь салбарын онцлогт илүү

тохирсон зөвлөмжийг боловсруулахад чухал ач холбогдолтой бөгөөд салбар тус бүр МУТС арга хэмжээг хэр үр дүнтэй хэрэгжүүлж байгааг харьцуулах боломжийг бий болгоно.



- ◆ Харилцан үнэлгээний үр дүнд гарч буй зөвлөмжүүд нь үр дүнд суурилсан бөгөөд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийг бууруулахад чиглэсэн хугацаатай даалгавруудыг харилцан үнэлгээний тайлангаар өгөх юм.
- ◆ Өмнөх харилцан үнэлгээний шатууд нь дунджаар 10 жил үргэлжилсэн тул энэ удаагийн харилцан үнэлгээний үйл явцыг илүү үр дүнтэй болгохын тулд дараагийн шатыг 6 жил болгож богиносгосон.

ФАТФ-аас урьдчилсан байдлаар зарласан дараагийн шатны харилцан үнэлгээний хуваариар Монгол Улсад 2028 онд 5 дахь шатны харилцан үнэлгээг хийхээр товлосон. Иймд, дараагийн шатны харилцан үнэлгээнд бэлтгэх, Монгол Улсын МУТС урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 54 дүгээр тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооноос мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2023–2030)”-ний дагуу МУТС чиглэлээр зохицуулалтын салбаруудын онцлогт тохирсон бодлогын цогц арга хэмжээг хэрэгжүүлж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлж, шинэ технологитой холбоотой эрсдэлийг бууруулах, оновчтой бодлого боловсруулж, МУТС, ҮОХЗДТ үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.

## ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

### НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НИЙТЭД САНАЛ БОЛГОН ГАРГАЖ БҮЙ БОНДЫН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГ ЭХЛҮҮЛЭЭ



Нийслэлийн Засаг даргаас нийтэд санал болгон гаргаж буй бондын анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх цан цохих ёслол боллоо. Ёслолын арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал, Нийслэлийн засаг даргын нэгдүгээр орлогч П.Сайнзориг, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Цогтбаатар, үндсэн болон туслах андеррайтерийн төлөөллүүд, холбогдох бусад хүмүүс оролцлоо.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ “УИХ-ас баталсан “Алсын хараа–2050”, “Зээлийн хүүг бууруулах стратеги” болон дунд, урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд олон улсад өрсөлдөхүйц хөрөнгийн зах зээлийг хөгжүүлж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний тоог өсгөж, үнэт цаасны арилжаа, хөрвөх чадварыг сайжруулж, хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх чиглэлээр Санхүүгийн зохицуулах хорооноос бодлогын арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлсний үр дүнд нийслэлийн Засаг даргын үнэт цаас ийнхүү олон нийтэд гарч байгаа нь хөрөнгийн зах зээлд бас нэгэн түүхэн үйл явдал болж байна. Олон улсад хот, мужууд нь томоохон бүтээн байгуулалт эхлүүлэх, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, санхүүгийн тогтвортой эх үүсвэртэй болох зорилгоор хөрөнгийн зах зээл дээр бонд гаргадаг. Жишээлбэл, АНУ нь дэлхийн хамгийн том бондын зах

зээлтэй улс бөгөөд бондын зах зээл нь 51 их наяд ам.доллараар үнэлэгддэг. Үүнээс орон нутгийн бонд буюу municipal bond-ын зах зээл нь 4 их наяд ам.доллараар үнэлэгддэг бөгөөд зээлжих зэрэглэлийн дундаж нь АА буюу хамгийн эрсдэл багатай, найдвартай гэдэг ангилалд багтдаг билээ. Хөрөнгийн зах зээлд нийслэлийн Засаг даргын бонд гарснаар шинэ бүтээгдэхүүний тоо нэмэгдэхээс гадна суурь өгөөжийн жишиг хүү бүрдэж, бондын үнэлгээ олон улсын жишгийн дагуу тогтдог болох, цаашлаад дотоодын бондын зах зээл хөгжиж, мэргэжлийн хөрөнгө оруулагчид болох хамтын нээлттэй, хаалттай ХОС-уудын хөрөнгийн зах зээл дэх оролцоо өсөх чухал ач холбогдолтой үйл явдал болж байна. Орон нутгийн бонд нь тухайн хот, аймгийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилготой, цаашлаад Монгол Улсын нийгмийн томоохон асуудлыг шийдсэнээр иргэдийн амьдралын чанарыг сайжруулах чухал ач холбогдолтойг онцолж хэлмээр байна. Манай Улсын хувьд одоо энэ зохицуулалт бүрдсэнийг түүчээлэн Нийслэлийн засаг даргаас бонд гаргаж байгаа нь хөрөнгийн зах зээлийн түүхэн нэг явдал болж байгаад баяр хүргэн нийтэд санал болгон гаргаж буй бондын анхдагч зах зээлийн арилжаанд амжилт хүсье” гэлээ.

### САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ КАМБОЖИЙН ЭДИЙН ЗАСАГ, САНГИЙН ЯАМНЫ ТӨЛӨӨЛӨГЧИД ТАНИЛЦЛАА



Камбож Улсын Эдийн засаг, сангийн яамны орлогч сайд ноён Н.Е.Рен Thirong-оор ахлуулсан төлөөлөгчид Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаатай танилцахын зэрэгцээ хорооны дарга Д.Баярсайхан болон холбогдох газрын дарга нартай уулзаж хамтын ажиллагаа болон туршлага солилцох талаар санал солилцлоо. Энэ үеэр төлөөлөгчдөд Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос хэрэгжүүлсэн бодлого, зохицуулалтын томоохон арга хэмжээний талаар танилцуулав. Тэр дундаа хүртээмжтэй,

ногоон санхүүгийн салбарыг хөгжүүлэх хүрээнд хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээ, үр дүн, туршлагаас онцлон танилцуулаад цаашид тогтвортой ногоон санхүүжилтийг нэмэгдүүлэх чиглэлд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудынхаа талаар мэдээлэл өгч харилцан санал солилцов.

Эдгээр төлөөлөгч нь НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөртэй хамтран “Монгол Улсын Санхүүгийн салбарын хөгжил, өрийн удирдлага, ногоон бонд, Үндэсний санхүүжилтийн нэгдсэн стратеги (INFF)-ийн туршлага судлах” ажлын хүрээнд манай улсад ажиллаж байгаа бөгөөд энэ үеэр ийнхүү Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаатай танилцахын зэрэгцээ удирдлагуудтай уулзалт хийж санал солилцсон юм.

### “АШИД КАПИТАЛ ББСБ” ХХК-ИЙН НИЙТЭД САНАЛ БОЛГОН ГАРГАЖ БУЙ БОНДЫН АРИЛЖААГ ЭХЛҮҮЛЛЭЭ



“Ашид капитал ББСБ” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй бондын анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх цан цохих ёслол боллоо. Ёслолын арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал, Монголын хөрөнгийн бирж ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Цогтбаяр, “Ашид капитал ББСБ” ХХК-ийн гүйцэтгэх захирал П.Батжаргал, “Голомт капитал ҮЦК” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Ган-Эрдэнэ болон холбогдох бусад хүмүүс оролцлоо.

Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ “Манай улсын хөрөнгийн зах зээл идэвхжиж олон шинэ бүтээгдэхүүн ар араасаа гарч байна. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ энэ оны нэгдүгээр улирлын байдлаар 11.8 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 80.7 хувиар өссөн бөгөөд ДНБ-ний 17.1 хувьтай тэнцэж байна. Мөн компанийн өрийн хэрэгслийн хоёрдогч зах

зээлийн арилжаагаар нийт 42.56 тэрбум төгрөгийн арилжаа явагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.58 дахин өссөн үзүүлэлт юм. Сүүлийн жилүүдэд банк бус санхүүгийн байгууллагууд бирж болон биржийн бус зах зээлд дээр бонд гаргаж санхүүжилт татах нь нэмэгдсэн. Ялангуяа сүүлийн дөрвөн жилийн хугацаанд ББСБ-аас гаргасан бондоор татсан санхүүжилтийн хэмжээ бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөд эзлэх хувь хэмжээ нь 5 дахин нэмэгдсэн нь манай хөрөнгийн зах зээл хэрхэн идэвхжиж, улс орны эдийн засагт гүйцэтгэх үүрэг нь өсөж байгаагийн тод илэрхийлэл юм. Мөн энэ нь хөрөнгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид, үнэт цаас гаргагчид, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үр дүн гэдгийг хэлэхийг хүсэж байна. “Ашид капитал ББСБ” ХХК нь дотоодын санхүүгийн зэрэглэл тогтоогч компаниар зэрэглэл тогтоолгож, аливаа барьцаагүйгээр бонд гаргах замаар санхүүжилт татсан анхны компани билээ. Өнгөрсөн онд анхны зээлжих зэрэглэлтэй бондыг зах зээлд санал болгож амжилттайгаар хөрөнгө татан төвлөрүүлсэн бол өнөөдрийн зах зээлд санал болгох гэж буй энэхүү бүтээгдэхүүн нь мөн адил дотоодын зэрэглэл тогтоох компаниар зэрэглэл тогтоолгосон бонд юм. Ингээд хөрөнгийн зах зээл дээр шинэ төрлийн бүтээгдэхүүн дахин нэгээр нэмж байгаа компанийн хамт олонд амжилт хүсье” гэлээ.

Тус компанийн олон нийтэд санал болгож буй энэхүү бонд нь 18 сарын хугацаатай, 18 хувийн хүүтэй 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй ба нийт 20 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэх юм байна.

### ЕВРО-АЗИЙН 40 ДЭХ УДААГИЙН ЧУУЛГА УУЛЗАЛТАД ОРОЛЦОВ



Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Н.Хүдэрчулуун болон холбогдох албан хаагчид Бүгд Найрамдах Киргиз Улсын нийслэл Бишкек хотноо болсон ФАТФ-ын Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 40 дэх удаагийн чуулга уулзалтад Монгол Улсыг төлөөлж оролцоод ирлээ.

Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлэг нь 2004 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд бүлгийн гишүүнээр Хятад, Энэтхэг, Казахстан, Киргиз, ОХУ, Таджикистан, Туркменистан, Узбекистан, Беларусь зэрэг 9 орон байдаг. Мөн бүлэгт Монгол, Итали, АНУ, Украин, Молдова, Турк, Армени, Польш, Серби, Монтенегро, Франц, БНСУ, Иран, Герман зэрэг 15 улс, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, ФАТФ, АНДМУТБ, Эгмонтын групп, НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага, Европын сэргээн босголт хөгжлийн банк зэрэг олон улсын болон бүс нутгийн 24 байгууллага ажиглагчийн статустай юм.

Тавдугаар сарын 25–31-ний өдрүүдэд болсон энэ удаагийн чуулга уулзалтаар Киргиз, Узбекистаны мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг танилцуулж, энэ чиглэлээр БНХАУ, Казахстан зэрэг холбогдох гишүүн орнууд мэдлэг, мэдээлэл түгээх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээгээ танилцуулав. Мөн виртуал хөрөнгөөс үүдэж болзошгүй эрсдэлийг бууруулах чиглэлээр типологи боловсруулж үйл ажиллагаандаа хэвшүүлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх хүрээнд авч буй арга хэмжээнүүдийн талаар хэлэлцэхийн зэрэгцээ Евро-Азийн бүсийн ээлжит гуравдугаар дахин үнэлгээ эхэлж байгаатай холбоотой гишүүн орнуудын анхаарах асуудал, бэлтгэл ажлын талаар мэдээлэл солилцсон юм. Япон улс энэ үеэр Евро-Азийн бүлэгт ажиглагч орноор элсэх хүсэлтээ өглөө.

Монгол Улс нь Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын төрлийн бүс нутгийн байгууллага болох Ази, номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлэг (АНДМУТБ)-т хамаардаг бөгөөд Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлэг (EAG)-ийн ажиглагч орноор 2012 онд элссэн юм.

## САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН НИЙГЭМЛЭГИЙН АЖЛЫН ХЭСГИЙН УУЛЗАЛТУУД БОЛЛОО

Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (СХН) нь олон улсын хэмжээнд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр



харилцан туршлага хуваалцаж, бодлого зохицуулалтын орчныг сайжруулах зорилготой ажилладаг. Нийгэмлэгт нийт 84 орны 89 санхүүгийн зохицуулагч байгууллага гишүүнчлэлтэй ажилладаг бөгөөд Монгол Улсаас Санхүүгийн зохицуулах хороо нийгэмлэгийн 7 ажлын хэсэгт идэвхтэй ажилладаг юм.

Тус нийгэмлэгийн Цахим санхүүгийн үйлчилгээ /DFS/, Олон улсын стандартыг зохистой хэрэгжүүлэх /GSP/ болон Санхүүгийн хүртээмжийн стратегийн талаар харилцан суралцах /FIS/ ажлын хэсгүүдийн хамтарсан уулзалт өнгөрсөн сарын 20–23-ны өдрүүдэд боллоо. Цахим санхүүгийн үйлчилгээний ажлын хэсэгт 64 орны төлөөлөл ажилладаг ба уг ажлын хэсгийн дэд дарга, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын Мөнгө угаахтай тэмцэх албаны ахлах хянан шалгагч Б.Цолмонтая энэ удаагийн уулзалтын “Шударга өрсөлдөөнийг дэмжих нь”, “Уганда Улсын төлбөр тооцооны зохицуулалтын орчныг сайжруулах нь” сэдэвт панел хэлэлцүүлгүүдийг удирдан явуулсны зэрэгцээ бүх ажлын хэсгийн нэгдсэн хурлын панелистээр ажиллаж өөрийн орны байр суурь, санал бодлыг илэрхийллээ. Мөн энэ үеэр Санхүүгийн зохицуулах хорооны албан хаагчид Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгээс “Шилдэг мэдлэг түгээгч” шагналыг гардуулсан юм.

## БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН НЯГТЛАН БОДОГЧДОД СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Банк бус санхүүгийн байгууллагын салбарын нягтлан бодох бүртэлийн орчныг боловсронгуй болгох зорилгоор 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан А/286/528 дугаар тушаалаар “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуй нэгж, байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг баталж, улмаар энэ оны нэгдүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж байна. Энэхүү журмыг хэрэгжүүлэх явцад тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, хэрэгжилтийг сайжруулах, нэгдсэн ойлголт, мэдээлэл өгөх зорилгоор банк бус санхүүгийн байгууллагын 160 гаруй нягтлан бодогчдод Санхүүгийн зохицуулах хороо, Татварын ерөнхий газар, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоотой хамтран сургалт, хэлэлцүүлгийг энэ сарын 30-ны өдөр зохион байгууллаа.

Энэ үеэр Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын өнөөгийн чиг хандлага, татварын эрсдэл, түүний удирдлага, нягтлан бодох бүртгэлийн журмыг хэрэгжүүлэх, эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын чиглэлээр холбогдох мэдээллийг өглөө. Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг сайжруулснаар санхүүгийн тайлагналын үнэн зөв, бодитой байх зарчим хангагдаж, санхүүгийн болон үйл ажиллагааны аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжтой юм.

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХАМТ ОЛОН САЛБАРЫН БАЙГУУЛЛАГУУДЫНХАА ХАМТ МОД ТАРИЛАА



“Тэрбум мод–Үндэсний хөдөлгөөн”-ний хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос санаачлан зохицуулалтын салбарын 14 байгууллагын хамт Баянзүрх дүүргийн Гачууртад байрлах олон улсын Эко цэцэрлэгт хүрээлэнд мод тарилаа.

Санхүүгийн зохицуулах хороо салбартаа ногоон санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын орчныг тэлэх ингэснээр байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд анхаарч ажилладаг. Энэ хүрээнд ногоон санхүүжилтийг дэмжих судалгаа хийх, зохицуулалтын зохистой орчныг нутагшуулах, бодлого тодорхойлогчийн хувьд ногоон санхүүжилтийг дэмжих замаар салбарын тогтвортой байдлыг хангахад анхаарахын сацуу салбарын нийт оролцогчдоо ч ногоон санхүүжилтийг хөгжүүлэхийг уриалдаг. Мөн “Тэрбум мод” тарих үндэсний хөдөлгөөнд салбарынхны оролцоог нэмэгдүүлэх санал санаачилгыг гаргахын зэрэгцээ хамт олноороо энэхүү хөдөлгөөнд дөрөв дэх жилээ нэгдээд байна. Тэрбум мод тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлснээр зөвхөн Монгол Улс төдийгүй дэлхийн дулаарлын эсрэг олон улсын зорилго зорилтуудад чиглэсэн чухал алхам учраас салбарын нийт байгууллагуудаа ч энэ хөдөлгөөнд нэгдэж ажиллахыг уриалж ийнхүү хамтдаа мод тарилаа.

Өдөрлөгт Санхүүгийн зохицуулах хорооны хамт олон болон Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, “Үнэт цаасны төрөлжсөн хадгаламжийн төв” ХХК, “Стандарт Инвестмент ҮЦК” ХХК, “БиДиСек ҮЦК” ХХК, “Гүүдсек ҮЦК” ХХК, “Ард санхүүгийн нэгдэл” ХК, “Монгол даатгал” ХК, “Практикал даатгал” ХХК, Үл хөдлөх хөрөнгийн бизнес эрхлэгчдийн Дээвэр нэгдсэн холбоо, Рэй менежмент групп ХХК, “Мобифинанс ББСБ” ХХК, “Лэнд МН ББСБ” ХХК, “Микрокредит ББСБ” ХХК-ийн нийт 300 гаруй ажилтан, албан хаагч оролцож 1360 мод тарилаа.

Санхүүгийн зохицуулах хорооныхон салбарын байгууллагуудынхаа хамтаар өмнөх жилүүдэд Сонгинохайрхан дүүргийн Баянхошуунд байрлах Бумбатын ам, Ар Гүнтэд байрлах “Инчьеон мөрөөдлийн төгөл”, Минж үржүүлэн нутагшуулах төвд байрлах банк бус санхүүгийн байгууллагуудын нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн болон Өвөрхангай аймгийн Хархорин суманд тус тус мод тариад байна.

## БАЙР СУУРЬ

## ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БОЛОН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОХ ӨӨРЧЛӨЛТҮҮД

Эхлэл 1–р нүүрт

Үнэт цаасны зах зээлийн хууль эрх зүйн болон зохицуулалтын онцлох өөрчлөлтүүдийн талаар Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөнтэй ярилцлаа.



Эдгээр хууль зүйн үндэслэл, практик шаардлагад тулгуурлан Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ–д өргөн барьсан. Түүнчлэн хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, татварын орчныг сайжруулах зорилгоор Компанийн тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль зэрэг дагалдах бусад хуулийн төслүүдийг боловсруулсан.

Энэхүү хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор олон улсын хөрөнгийн зах зээл дээрх шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийг Монгол Улсын хөрөнгийн зах зээлд нэвтрүүлэх эрх зүйн орчин бүрдэх, хөрөнгө оруулалт нэмэгдэх, улмаар хувийн хэвшлийн компаниуд хөрөнгийн зах зээлээр дамжуулан урт хугацаат санхүүжилт татах үйл явц хялбаршиж, дотоод болон гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулах сонирхол, санхүүгийн зах зээл дээрх мөнгөн урсгал нэмэгдэх зэрэг ач холбогдолтой.

**Хөрөнгө оруулагчдын хувьд татварын орчин ойлгомжтой, тодорхой байх нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад ихээхэн чухал байдаг. Тэгвэл үүнтэй холбоотойгоор хөрөнгийн зах зээлд татварын ямар өөрчлөлт бий болсон вэ?**

Улсын Их Хурлаас 2023 оны 11 дүгээр сарын 10–ны өдөр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг тус тус баталсан.

Эдгээр хуульд Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгч дотоодын үнэт цаасны зах зээлд шууд хөрөнгө оруулан худалдан авсан хувьцаа болон өрийн хэрэгслээ борлуулахад татвар ногдуулах орлогыг нийт дүнгээс тооцдог ялгавартай зохицуулалт үйлчилж байсныг Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн адилаар тухайн хувьцаа, үнэт цаасыг худалдан авахад гарсан холбогдох зардлыг хасаж тооцох зохицуулалтыг тусгаж өгсөн.

Мөн дээрх хуулийн хүрээнд Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч, Засгийн газар, аймаг, нийслэлийн дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан хувьцаа болон өрийн хэрэгсэл борлуулсны орлогод ногдох албан татварыг 2024–2026 онд 90 хувиар, 2027–2029 онд 50 хувиар тус тус хөнгөлөхөөр заасан.

Түүнчлэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэгт үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв болон кастодианы үйл ажиллагаа эрхлэгч этгээд нь дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан Засгийн газар, аймаг, нийслэлийн болон Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаас борлуулсны орлогод ногдуулах албан татварыг суутган, төсөвт төлж, тайлагнах үүрэгтэй байхаар зохицуулсан.

Эдгээр өөрчлөлтүүд нь манай улсын хөрөнгийн зах зээлийг дэмжих, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үнэт цаасны зах зээлийг идэвхжүүлэх зэрэг томоохон зэрэг өөрчлөлтүүдийг авчрах хүлээлттэй байгаа юм.

Үүнээс гадна хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхтэй холбоотойгоор “Дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан Засгийн газар, аймаг, нийслэлийн болон Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн өрийн хэрэгсэл (бонд), хувьцаа, бусад үнэт цаасыг борлуулсны орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох, суутган тооцох, төсөвт төлөх, тайлагнах журам”-ыг боловсруулж, Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/105/239 тоот хамтарсан тушаалаар батлуулаад байна. Уг журмыг баталснаар хөрөнгө оруулагчдын татварын харилцааг хялбаршуулах боломж бүрдэж, тайлан гаргах үүргээс чөлөөлж буйн зэрэгцээ хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлэх юм.

**Таны зүгээс дээрх хуулиудын нэмэлт өөрчлөлттэй холбоотойгоор ялангуяа гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, нэмэгдүүлэх чиглэлд хийгдэх ажлуудыг хэрхэн харж байна вэ? Цаашид ямар арга хэмжээг авч, хэрэгжүүлэхээр төлөвлөж байна вэ?**

Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг хурдасгахад гадаад, дотоодын мэргэжлийн буюу институциональ хөрөнгө оруулагчдын оролцоо нэн чухал бөгөөд тэр дундаа гадаадын хөрөнгө оруулагчдыг татаж, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын суурь тогтолцоог бүрдүүлснээр хөрөнгийн зах зээлийн идэвх нэмэгдэж, дотоодын аж ахуйн нэгжүүд шаардлагатай урт хугацааны санхүүжилтээ хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлэх, жижиг хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын сангуудаар дамжуулан урт хугацааны тогтвортой өгөөж хүртэх, хөрөнгийн дахин хуваарилалт хийгдэж, эдийн засгийн урт хугацааны өсөлтийг дэмжиж, компаниуд цар хүрээгээ тэлэн олон улсын зах зээл дээр гарах давуу талтай юм. Учир нь мэргэжлийн хөрөнгө оруулагчид компанийн засаглалын олон улсын зарчмуудыг нэвтрүүлэхэд маш хүчтэйгээр оролцож бизнесийн ёс зүй, нийгмийн хариуцлага, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоо, мэдээлэл, тайлагналын стандартуудыг зах зээлд нутагшуулдаг. Энэ ч утгаараа нийт зах зээлд оролцогчдын хүний нөөцийг мэргэшүүлэх, чадваржуулах, байгууллагын соёлыг хөгжүүлэх, санхүүгийн шинэлэг технологи, стандарт, хандлагуудыг зах зээлд нэвтрүүлэх

зэрэг ажлыг Санхүүгийн зохицуулах хороо мэргэжлийн хөрөнгө оруулагчидтай гар нийлэн хамтран хэрэгжүүлж, үр дүнд хүрэх боломжтой гэж үздэг. Ингэснээр бид олон улсын зах зээлд идэвхтэй тоглогч болох нөхцөл бүрдэнэ.

Энэ хүрээнд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр мэргэжлийн урт хугацаат хөрөнгө оруулагчдыг хөрөнгийн зах зээлд татан оролцуулах, идэвхтэй хөрөнгө оруулалт хийх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалтыг ялгаатай тогтоож, хамтын сангийн хөрөнгө оруулалт хийх санхүүгийн хэрэгсэл, төрлийг өсгөн хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг дэмжсэн зохицуулалтыг бүрдүүлж өгсөн.

Түүнчлэн гадаадын мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг Монгол Улсын хөрөнгийн зах зээлд оролцох идэвх сонирхлыг нэмэгдүүлэх хүрээнд нээлттэй компаниудыг гадаадын болон дотоодын хөрөнгийн бирж дээр давхар бүртгэх, хадгаламжийн бичиг (depository receipt) гаргахад дэмжлэг үзүүлэх, хувьцаат компаниудын тайлан, мэдээ, мэдээллийг англи хэл дээр гаргах, түгээх, хөрөнгө оруулагчидтай харилцах харилцааг сайжруулах зэрэг чиглэлд олон улсын зохицуулагч байгууллага, холбоо болон санхүүгийн байгууллагуудтай өргөн хүрээнд хамтран ажиллаж байна.

Тухайлбал, Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг олон улсад сурталчлан таниулах, Ази, Номхон далайн орнуудын хөрөнгийн зах зээлтэй холбох, гадаадын хөрөнгө оруулагчийг татах зорилгоор “Монголын хөрөнгийн зах зээлийг холбох нь” цуврал арга хэмжээг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Хонконгд амжилттай зохион байгуулсан.

Цаашид энэхүү арга хэмжээг олон улсын зохицуулагч байгууллага, холбоо болон санхүүгийн байгууллагуудтай хамтран Сингапур, Солонгос зэрэг Ази, Номхон далайн орнуудын санхүүгийн төв болсон улс орнуудад зохион байгуулахыг зорьж байгаа бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос авч хэрэгжүүлж буй дээрх шат дараалсан бодлогын арга хэмжээнүүдийн үр дүнд ирэх жилүүдэд гадаадын хөрөнгө оруулагчдын Монгол Улсад хөрөнгө оруулах идэвх, сонирхол улам нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байна.

## ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

### ТЕКСТИЛИЙН САЛБАРТ ОЛГОХ БОЛОМЖТОЙ ОЛОН УЛСЫН НОГООН САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРҮҮД

ТоС Холбооны Монголын ногоон санхүүжилтийн эх үүсвэрийн судалгааны хэсгээс

#### ХӨДӨӨ АЖ АХУЙН ЖИЖИГ ФЕРМИЙН АЖ АХУЙД ЗОРИУЛСАН ДАСАН ЗОХИЦОХ ХӨТӨЛБӨР (ASAP)

Хөдөө аж ахуйн жижиг фермийн аж ахуйд зориулсан дасан зохицох хөтөлбөр (ASAP) нь IFAD-н үлгэр жишээ хөтөлбөр бөгөөд жижиг фермийн аж ахуйд байгаль орчны болон уур амьсгалын санхүүжилтийг чиглүүлэх зорилготой хөтөлбөр юм. Тус хөтөлбөр нь IFAD-н хөрөнгө оруулалтын процесст багтсан байдаг тул IFAD-н чанарын хяналт болон хяналт шалгалтын системийг давхар ашиглах боломжтой байдаг. ASAP-н эхний үе шат буюу 2012 – 2017 оны хооронд IFAD 305 сая ам.долларыг ASAP-н буцалтгүй тусламжид зориулж, энэ хүрээнд 41 орны 5 сая гаруй жижиг фермийн аж ахуйчдад уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах, илүү тэсвэрлэх чадвартай амьжиргааг бий болгоход дэмжлэг үзүүлсэн. ASAP нь IFAD-н хөрөнгө оруулалтын процесст уур амьсгалын эрсдэлийг тусгах байдлыг нэмэгдүүлж, жижиг фермийн аж ахуйчид уур амьсгалын өөрчлөлтөөс өөрсдийн хөрөнгийг хамгаалахад нь зориулж хэд хэдэн инновацлаг технологи, хэрэгслүүдийг хөгжүүлсэн байдаг. ASAP2 хөтөлбөр нь Норвегийн хөгжлийн хамтын ажиллагааны агентлагаас 9.5 сая ам.доллартой тэнцэх санхүүжилт, Шведийн олон улсын хамтын ажиллагааны агентлагаас 5.9 сая ам.доллартой тэнцэх санхүүжилтийг бүрдүүлсэн. ASAP2 нь дотоодын яамд, судалгааны байгууллагууд, фермийн аж ахуйчид, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд чадавх бэхжүүлэх болон техник туслалцаагаар дамжуулан уур амьсгалын асуудлыг түгээн дэлгэрүүлэх, цаашлаад IFAD-н хөрөнгө оруулалтыг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нэмэлт хамтын санхүүжилтийг хөшүүрэгдэхэд ашиглах боломжийг нээж байна. ASAP-н эхний шатанд мөрдөгдөж байсан дэмжлэг Умардын хоёр улстай байгуулсан хувь нэмрийн хэлэлцээрт ижил хэлбэрээр тусгагдаад байна. Шинэчилсэн үүрэг амлалтын хүрээнд IFAD-н хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүд дэх уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой нэмэлт зардлыг

шийдвэрлэх, тогтвортой хөгжлийн зорилтуудад хувь нэмэр оруулах тухай тусгажээ. ASAP2 итгэлцлийн сангийн нийт зорилтот хэмжээ нь 100 сая ам.доллар.

ASAP сангийн үйл ажиллагаа нь дараах үйл ажиллагаануудад чиглэгдэнэ. Үүнд:

- ◆ Бодлогын хамтын ажиллагаа – IFAD дахь хөдөө аж ахуйн байгууллагуудыг дэмждэг гишүүн орнууд олон улсын уур амьсгалын үүрэг амлалт, үндэсний хэмжээнд дасан зохицох тэргүүлэх чиглэлүүдийг биелүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх;
- ◆ Уур амьсгалын эрсдэлийн үнэлгээ – уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэхийн тулд хөрөнгө оруулалтыг анх төлөвлөхдөө уур амьсгалын эрсдэлтэй холбоотой мэдээллийг системтэйгээр ашиглах;
- ◆ Эмэгтэйчүүдийг чадавхжуулах – уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийн ашиг хүртэх байдлыг нэмэгдүүлэх;
- ◆ Хувийн хэвшлийн оролцоо – уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах болон дасан зохицох үйл ажиллагаанд хувийн хэвшил болон фермийн аж ахуй эрхлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх;
- ◆ Уур амьсгалын үйлчилгээ – уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэхийн тулд хөрөнгө оруулалтыг анх төлөвлөхдөө уур амьсгалын эрсдэлтэй холбоотой мэдээллийг системтэйгээр ашиглах;
- ◆ Байгалийн нөөцийн менежмент ба засаглал – шийдвэр гаргах түвшинд фермийн аж ахуй эрхлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг мэдрэмтгий байгалийн нөөцийн менежмент, засаглалыг сайжруулах технологийн шинэчлэл хийх;

- ◆ Мэдлэгийн менежмент – уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хөдөө аж ахуйг хөгжүүлэх мэдлэг, мэдээлэл, танилцуулгыг нэмэгдүүлэх.

**Уур амьсгалын зорилт:** Сааруулах, дасан зохицох, аль алинд хамаарах

**Санхүүжилтийн механизм:** Буцалтгүй тусламж

- ◆ Олон улсын болон бүсийн хэмжээний буцалтгүй тусламж (бүс нутгийн хэмжээний стратегийн ач холбогдлоос шалтгаална)
- ◆ Тодорхой улс оронд зориулсан буцалтгүй тусламж (байгууллагын дотоодын чадавх, хэрэгжилт болон бодлогын чадавхыг сайжруулах).

**Буцалтгүй тусламжийн хэмжээ:**

- ◆ Жижиг хэмжээний буцалтгүй тусламж: 500,000 ам.доллар хүртэлх
- ◆ Том хэмжээний буцалтгүй тусламж: 500,000 – 3.5 сая ам.доллар

**Санхүүжилтийн хугацаа:** 3–5 жил

**Жендерийн бодлого:** IFAD–н18 жендерийн бодлоготой ижил.

Жендерийн бодлого нь дараах 3 стратегийн зорилттой. Үүнд:

- ◆ Эдийн засгийн үйл ажиллагаанаас ашиг хүртэх хөдөөгийн эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн оролцоог нэмэгдүүлж, эдийн засгийн чадавх бүрдүүлэх.
- ◆ Орон нутгийн байгууллагад эмэгтэй, эрэгтэй хүмүүс дуу хоолойгоо ижил тэгш хүргэх боломжоор хангах.
- ◆ Эмэгтэй, эрэгтэй хүмүүс эдийн засаг, нийгмийн ашиг шимийг ижил тэгш хүртэж, ижил тэнцүү ажлын ачаалалтай ажиллаж, хувь нэмрээ оруулах.

Төслүүд болон хөрөнгө оруулалтын загварууд нь дараах байдлаар сонгогдоно:

*Санхүүжүүлэхээс өмнөх чанарын шалгуур:*

- ◆ ASAP–н санхүүжилтийг хамтын санхүүжилтээр ашиглаж буй төслүүд нэмэлт үнэ цэнэ буюу 'additionality' (буцалтгүй тусламж нь төсөлд нэмэлт үнэ цэнэ авчир байх, бусад төр ба хувийн хэвшлийн үйл ажиллагааг дуурайж, давтаагүй байх) үүсгэж байгаа

эсэх

- ◆ ASAP–н дэмжлэгтэй хэрэгжих төсөл нь тухайн улсын засгийн газар, IFAD–н бүс хариуцсан нэгж, эмэгтэйчүүд болон тусгай хэрэгцээ бүхий жижиг фермийн аж ахуйчдад үр ашиг хүртээж байгаа эсэх
- ◆ ASAP–н санхүүжилт нь уур амьсгалын өөрчлөлтөд ихээхэн эмзэг мэдрэмтгий улс орнуудын олон тооны жижиг фермийн аж ахуйчдад хүрч чадах эсэх, ASAP–н санхүүжилтийг уур амьсгалын санхүүжилтийн урсгалыг нэмэгдүүлэх суурь баазыг бүрдүүлэхэд ашиглах эсэх

*ASAP–н үр дүнгийн тогтолцооны бэлтгэл болгож санхүүжүүлэхээс өмнө хийгдэх тоон үнэлгээ:*

- ◆ Уур амьсгалын өөрчлөлтийг тэсвэрлэх байдал нь нэмэгдэх ядуу жижиг фермийн аж ахуйчдын тоо
- ◆ Нийт шаардлагатай хөрөнгө оруулалтын дүн
- ◆ Төслийн хөшүүргийн харьцаа: ASAP–н санхүүжилт ба ASAP–н бус санхүүжилт
- ◆ Зайлсхийх, тусгаарлах боломжтой хүлэмжийн хийн ялгарал, тонноор
- ◆ Бууруулах, зайлсхийх боломжтой газрын ба экосистемийн доройтлын хэмжээ
- ◆ Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй арга туршлагын хүрээнд сайжирсан талбайн хэмжээ, га
- ◆ Усны хүртээмж нь дээшилсэн өрх, үйлдвэрлэл, үйлчилгээний тоо
- ◆ Уур амьсгалын эрсдэлийн менежмент, байгаль орчин, байгалийн нөөцийн менежмент, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд оролцсон хувь хүн, бүлэг хүмүүс, байгууллагуудын тоо
- ◆ Одоо байгаа болон шинээр баригдах уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хөдөөгийн дэд бүтцийн өртөг
- ◆ Төслөөс хувь нэмрээ оруулах боломжтой олон улсын болон үндэсний хэмжээний уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар зохион байгуулсан/зохион байгуулах арга хэмжээний тоо

## ХУВИЙН ХЭВШЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ХӨТӨЛБӨР (PSFP)

IFAD-н хүнсний аюулгүй байдлыг сайжруулж, хөдөөгийн ядуурлыг бууруулах үр нөлөөг нэмэгдүүлэхэд одоогийн үйл ажиллагаа, уламжлалт партнеруудаас хол давсан нэмэлт хөрөнгө оруулагчид шаардлагатай. Сүүлийн жилүүдэд хөдөө аж ахуйн салбарт олгох хөгжлийн туслалцаа жилд дунджаар 10.5 тэрбум ам.доллараар хэмжигдэж, хэрэгцээг даган өсөхгүй байгаа нь өлсгөлөнг зогсооход шаардлагатай нийт санхүүжилтийн хэрэгцээний хаана ч хүрэхгүй байгаа юм. Зөвхөн Африкийн улсуудыг авч үзэхэд дараагийн 20 жилд 440 сая гаруй залуучууд хөдөлмөрийн зах зээлд орох бөгөөд ингэхийн тулд хөдөө аж ахуйн хөгжлийн туслалцааг нэмэгдүүлэх нь хамгийн наад захын шаардлага болно. Дэлхийн хөдөө аж ахуй, хүнсний системийн цөм болох жижиг фермийн аж ахуйчид, хөдөөгийн бичил, жижиг дунд ААН-үүдийг дэмжих нь нэг шийдэл байж болох хэдий ч тэд бизнесээ өргөжүүлэх, тогтвортой хадгалахад шаардлагатай зах зээл, санхүүжилт, үйлчилгээг хангалттай хүртээмжтэй авч чадахгүй байсаар байна. Тэдэнд тулгамдаад буй асуудал болон хэрэгцээг хүн бүхэн мэддэг юм шиг боловч хөрөнгө оруулагчид жижиг фермийн аж ахуй, хөдөөгийн БЖДҮ нарт хүрч очих мэдлэг, чадавх хомс байсаар байна. Энэхүү зөрүүг арилгахын тулд хөрөнгө оруулагчид хөдөө аж ахуйн салбар, хөдөөгийн нөхөрлөл, хоршоодын талаар маш сайн мэдлэгтэй байхыг шаардана. IFAD-н Хувийн хэвшлийн санхүүжилтийн хөтөлбөр (PSFP) нь хөдөө аж ахуйн салбар дахь БЖДҮ нарт оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилготой байгуулагдсан сан юм. Сан нь жижиг фермийн аж ахуй эрхлэгчид, хөдөөгийн ядуу болон БЖДҮ нарт шууд санхүүжилт, хөрөнгө оруулалт хийхээс гадна санхүүгийн зуучлагч компаниудаар дамжуулан зээл, санхүүжилтийг мөн олгодог.

Санхүүжилтийн механизм: Зээл, хувьцааны хөрөнгө оруулалт, эрсдэл бууруулах, хуваалцах, баталгаа олгох. Энгийн болон холимог санхүүжилт аль алийг олгох боломжтой.

### Гол зорилтот салбар, чиглэл:

- ◆ Залуучуудын хөдөлмөр эрхлэлт
- ◆ Эмэгтэйчүүдийг чадавхжуулах
- ◆ Жижиг фермийн аж ахуйчдын байгаль орчны тогтвортой байдал, уур амьсгалд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх
- ◆ Ядуу буурай хөдөөгийн үйлдвэрлэгч, хоршоодыг дэмжих.



# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

## НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

Нэр дэвшүүлэх хороо нь компанийн засаглалын тогтолцооны чухал хэсэг бөгөөд тус хороо нь төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн гишүүдэд тавигдах шаардлага болон гүйцэтгэлийн үнэлгээг хариуцан ТУЗ-ийн бүрэлдэхүүнд хамгийн сайн тохирох нэр дэвшигчийг сонгох үүрэгтэй.

Түүнчлэн, нэр дэвшүүлэх хороо нь хорооны үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, шийдвэрийг хянах чиг үүрэг бүхий даргатай байна. Хорооны даргын үүргийг уламжлал ёсоор ТУЗ-ийн дарга гүйцэтгэдэг байсан ч дараах хүчин зүйлсийн нөлөөгөөр нэгэнт өөрчлөгдсөн. Үүнд:

- ◆ Энгийн гишүүн, томоохон хувьцаа эзэмшигчийг төлөөлдөг боловч компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцдоггүй.
- ◆ Хараат бус гишүүн, гаднаас сонгогдсон туршлагатай гишүүн гүйцэтгэдэг.

Нэр дэвшүүлэх хороо нь энгийн болон хараат бус гишүүдээс бүрдэх ба хорооны даргыг ТУЗ сонгодог.

### НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ҮҮРЭГ

Нэр дэвшүүлэх хороо нь чиг үүрэг, хариуцлагаа тодорхойлсон баримт бичиг дүрэм, журамтай байх бөгөөд дараах чиг үүргийг голчлон хэрэгжүүлдэг. Үүнд:

#### ТУЗ-ийн залгамж халааг хэрэгжүүлэх:

ТУЗ-ийн гишүүд, компанийн гүйцэтгэх удирдлагын залгамж халаанд учирч болзошгүй эрсдэл, төлөвлөгдөөгүй нөхцөл байдалд бэлэн байх үүднээс тэдгээрийн сонгон шалгаруулалтад хяналт тавих шаардлагатай. Эс бөгөөс компанийн хувьд урьдчилан тооцох боломжгүй үр дагаварт хүргэж болзошгүй.

#### ТУЗ-ийн жилийн үнэлгээ:

Компанийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан ТУЗ-ийн чадамжийг жил бүр үнэлэх шаардлагатай бөгөөд энэ нь байгууллагын зорилгод нийцсэн шийдвэр гаргах боломжийг олгодог.

#### Компанийн стратегитай уялдуулах:

Сүүлийн үед шинээр гарч ирж буй үүрэг бол компанийн урт хугацааны стратегийг тодорхой болгож, орчин нөхцөлд нийцүүлэн, компанийн хэрэгцээнд үндэслэн нэр дэвшигчийг сонгох явдал аж.

#### ТУЗ-ийн гишүүдийн сургалт, хөгжил:

ТУЗ-ийн гишүүнээр анх томилогдож буй гишүүдэд нэр дэвшүүлэх хороо компанийн стратеги, зорилго, соёл, удирдлагын талаар мэдээлэл өгөх үүрэгтэй ба энэхүү сургалт нь ТУЗ-ийн гишүүдэд үүргээ гүйцэтгэхэд дэмжлэг болох учиртай. Мөн ТУЗ-ийн гишүүдэд мэдлэг олгох, шинэ мэдээлэл хүргэх зэргээр тэдгээрийн ур чадварыг дээшлүүлэх сургалтын жилийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай.

Нэр дэвшүүлэх хороодын үйл ажиллагааны талаар тогтсон буюу хэвшсэн заавар, зөвлөмж байхгүй хэдий ч зарим сайн туршлагаудаас дурдвал:

### ХҮЧТЭЙ, ЧАДВАРЛАГ ТУЗ БАЙГУУЛЖ, ГҮЙЦЭТГЭЛИЙГ НЬ ҮНЭЛЭХ

Чадварлаг нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүдийг дараах байдлаар бүрдүүлэхэд чиглэгдэнэ:

- ◆ Компани болон түүний үйл ажиллагааны талаарх мэдлэг, туршлага
- ◆ Нийгмийн төрөл бүрийн төлөөлөл
- ◆ Ёс суртахуун, шударга байдал
- ◆ Ур чадвар, олон талт байдал.

## ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГЫГ ТОДОРХОЙ БОЛГОХ

Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын үүрэг, хариуцлага тодорхой байх:

- ◆ ТУЗ-ийн дарга, гишүүдийн албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах
- ◆ холбогдох удирдлагуудад үүрэг, хариуцлагыг шилжүүлэх
- ◆ гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтнуудын чиг үүргийг тодорхойлох

## ЭРСДЭЛИЙГ БОДИТОЙГООР УДИРДАХ

Дараах эрсдэлийг тодорхойлж, үнэлэх:

- ◆ Компанийн санхүү
- ◆ Үйл ажиллагаа
- ◆ Хууль эрх зүй, улс төрийн орчин
- ◆ Зах зээл болон эрх зүйн холбогдох өөрчлөлтүүд.

Нэр дэвшүүлэх хороо нь эрсдэлийг бууруулах тогтолцоог боловсруулж, компанийн эрсдэлийг удирдах хандлагыг стратегийн хувьд чиглүүлэх үүрэгтэй.

## ШИЙДВЭР ГАРГАХДАА ШУДАРГА БАЙДАЛ, ЁС ЗҮЙГ ЧУХАЛЧЛАХ

Ашиг сонирхлын зөрчлийг урьдчилан мэдэгдэж, ашиг сонирхлын зөрчилтэй үед санал өгөхөөс татгалзана. Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-д шударга ёс, байгууллагын соёлыг бий болгоно.

*Нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүний жишээ:*

## APPLE :

- ◆ Сюзан Вагнер, Хорооны дарга, эмэгтэй (BlackRock-ийг үүсгэн байгуулагчдын нэг, Lehman Brothers компанийн дэд ерөнхийлөгч асан)
- ◆ Альберт А.Гор бага, эрэгтэй (АНУ-ын 45 дахь дэд ерөнхийлөгч, нобелийн шагналтан)
- ◆ Андреа Юнг, эмэгтэй (Grameen America ашгийн бус санхүүгийн байгууллагын ерөнхийлөгч бөгөөд гүйцэтгэх захирал, Avon-ын ТУЗ-ийн ахлах зөвлөх асан)

## MICROSOFT:

- ◆ Жон Томпсон, Хорооны дарга, эрэгтэй (сагсан бөмбөгчин, НБА-ийн аварга асан)
- ◆ Тери Лист-Столл, эмэгтэй (Gap Inc-ийн Гүйцэтгэх дэд ерөнхийлөгч, Санхүү хариуцсан захирал асан)
- ◆ Сандра Петерсон, эмэгтэй (Clayton, Dubilier & Rice компанийн бизнесийн түнш)

*Эх сурвалж. [www.corporatefinanceinstitute.com](http://www.corporatefinanceinstitute.com)*

## ФИНТЕК БА РЕГТЕК

## 2024 ОНЫ ТЕХНОЛОГИЙН ШИЛДЭГ 10 КОМПАНИ

## 10. ADOBE



Орлого: 19.41 тэрбум ам.доллар  
Ажилтан: 29,945

Гүйцэтгэх захирал: Шантану Нараен

Үүсгэн байгуулагдсан: 1982

Adobe байнга шинийг илэрхийлдэг технологийн салбарын тэргүүлэгч компани бөгөөд жилд ойролцоогоор 3.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг судалгаа, шинжилгээнд зарцуулдаг. Үүний үр дүнд хиймэл оюун ухаан болон үүлэн технологийн салбарт ахиц дэвшил гарсаар байна. Adobe компанийн зах зээлийн үнэлгээ нь 200 тэрбум ам.доллар бөгөөд дижитал медиа болон контент бүтээх салбарт өөрийн нөлөөллөө хадгалсаар байна. Тус компани нь бүтээлч мэргэжилтнүүдийн 90 гаруй хувь нь ашигладаг Photoshop, PDF зэрэг зайлшгүй шаардлагатай Acrobat зэрэг программ хангамжийн бүтээгдэхүүнээрээ хэрэглэгчдийн анхаарлыг татдаг.

## 9. ORACLE



Орлого: 50 тэрбум ам.доллар  
Ажилчид: 143,000  
Гүйцэтгэх захирал: Сафра Катз

Үүсгэн байгуулагдсан: 1977

Oracle нь инновацийн салбарт тэргүүлэгч компани бөгөөд 12 сарын хугацаанд 8.91 тэрбум ам.долларыг өгөгдлийн сангийн технологи, үүлэн технологийн дэд бүтцийг хөгжүүлэхэд зарцуулж, сүүлийн үеийн хиймэл оюун ухааны программуудыг хөгжүүлж байна. Тус компани нь дэлхий даяар 430,000 гаруй үйлчлүүлэгчтэй, үүлэн технологи болон байгууллагын программ хангамжаараа хэрэглэгчдэд дунд алдартай. Oracle нь зах зээлд хүчтэй нөлөө үзүүлж байгаа нь 2023 оны санхүүгийн жилийн орлогоос харагдах бөгөөд технологийн салбарт тогтвортой, жигд өсөлтийг үзүүлсээр байна.

## 8. TENCENT



Орлого: 85 тэрбум ам.доллар

Ажилтан: 105,417

Гүйцэтгэх захирал: Ма Хуатэн

Үүсгэн байгуулагдсан: 1998

Tencent нь тоглоом, хиймэл оюун ухаан, үүлэн тооцоолол зэрэг салбарт их хэмжээний хөрөнгө оруулалт хийж, Хятад болон бусад орнуудад дижитал эдийн засгийг хөгжүүлэх чиглэлээр технологийн салбарын шинэчлэлийн тэргүүн эгнээнд орсоор байна. Тус компани нь тэрбум гаруй хэрэглэгчдийн өдөр тутмын нийгмийн болон худалдааны харилцааны салшгүй хэсэг болох WeChat-ыг багтаасан олон төрлийн дижитал экосистемээрээ хэрэглэгчдэд хэдийнээ танил болсон компани юм.

## 7. SAMSUNG



Орлого: 194.23 тэрбум ам.доллар  
Ажилтан: 270,372

Гүйцэтгэх захирал: Хан Жон Хи

Үүсгэн байгуулагдсан: 1938 он

Samsung нь хиймэл оюун ухаанд зориулсан өндөр нягтралтай санах ойг хөгжүүлэх, эвхэгддэг утасны технологийг анхдагч болгоход онцгой анхаарал хандуулж, инновацад ихээхэн хөрөнгө оруулалт хийдэг. Тус компани нь ухаалаг гар утас, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл зэрэг өдөр тутмын бүтээгдэхүүнд хамгийн сүүлийн үеийн технологийг нэвтрүүлж, хэрэглэгчийн туршлага, холболтыг сайжруулснаар хэрэглэгчдэд ихээхэн нөлөөлдөг. Самсунг нь өндөр хүчин чадалтай тооцоолол, дээд зэрэглэлийн хэрэглээний электроникийн стратегийн өргөтгөлөөр дамжуулан зах зээлд хүчтэй нөлөө үзүүлж, технологийн салбарын дэлхийн зах зээлд эзлэх хувийг тогтмол өсгөж байна.

## 6. BROADCOM



Орлого: 35.8 тэрбум ам.доллар

Ажилчид: 20,000 гаруй

Гүйцэтгэх захирал: Хок Тан

Үүсгэн байгуулагдсан: 1991

Broadcom нь ухаалаг гар утаснаас эхлээд гэрийн сүлжээний төхөөрөмж хүртэл өдөр тутмын төрөл бүрийн технологийн бүтээгдэхүүнд хэрэглэгддэг чухал бүрэлдэхүүн хэсгүүдийг зах зээлд нийлүүлдэг. Тус компани нь судалгаа, шинжилгээнд их хэмжээний хөрөнгө оруулалт хийж, хагас дамжуулагч болон дэд бүтцийн программ хангамжийн шийдлүүдийг боловсронгуй

болгож, инновацыг хөгжүүлсээр байна.

### 5. NVIDIA



Орлого: 27 тэрбум ам.доллар

Ажилтан: 29,600

Гүйцэтгэх захирал: Женсен Хуан

Үүсгэн байгуулагдсан: 1993

NVIDIA нь тоглоомын болон мэргэжлийн график дүрслэлд анхдагч дэвшилтүүдийг нэвтрүүлж, хүчирхэг GPU болон сүүлийн үеийн хиймэл оюун ухааны технологийн дэвшлийг нэвтрүүлснээр хэрэглэгчдэд хэдийнээ танигдсан. Тус компани инновацын салбарт тэргүүлсээр байгаагийн нэгэн жишээ нь 2023 оны санхүүгийн жилд орлого 41 хувийн өсөлтийг үзүүлсэн. Техник хангамжийн хурдасгах болон программ хангамжийн шийдлүүдийг нэгтгэсэн NVIDIA нь зах зээлд нөлөөллөө хадгалж, салбартаа манлайлсаар байна.

### 4. AMAZON



Орлого: 574.8 тэрбум ам.доллар

Ажилчид: 1,525,000

Гүйцэтгэх захирал: Энди Жасси

Үүсгэн байгуулагдсан: 1994 он

Амазон нь дэлхийн онлайн худалдааны зах зээл дээр хэрэглэгчдийн худалдан авалтын түүхэнд хувьсгал хийж, дэлхий даяар сая сая хүмүүст тав тухтай, хүртээмжтэй худалдан авалт хийх нөхцөлийг олгодог. Тус компани нь байнга шинэчлэгдэж, үйлчилгээгээ цахим худалдаанаас гадна Amazon Web Services (AWS) ашиглан үүлэн тооцоолол гэх мэт салбарт өргөжин хөгжиж байна. 2023 онд 90.8 тэрбум долларын орлого олсон бөгөөд нисгэгчгүй онгоц зэрэг технологийн дэвшилтэт санаа нь шинэ хуудсыг нээж байна. Амазон компанийн зах зээлийн үнэлгээ нь 1.6 тэрбум ам.доллараас давсан ба дэлхийн хэмжээнд жижиглэн худалдаа төдийгүй дижитал дамжуулалт, логистик, технологийн салбарыг бүрдүүлэн зах зээлд томоохон нөлөөллөө хадгалсаар байна.

### 3. GOOGLE



Орлого: 307,394 тэрбум ам.доллар

Ажилтан: 182,502

Гүйцэтгэх захирал: Сундар Пичай

Үүсгэн байгуулагдсан: 1998

Google-ийн толгой компани болох Alphabet нь Google Хайлт, YouTube, Android зэрэг олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдээрээ дамжуулан хэрэглэгчдэд хүрдэг. Тус компани

нь Google X-ийн судалгааны салбараараа дамжуулан хиймэл оюун ухаан, үүлэн тооцоолол, бие даасан технологийн дэвшлийг нэвтрүүлж, инновацын салбарт тэргүүлж байна. 2023 оны санхүүгийн жилд 264.23 тэрбум ам.долларын орлоготой, 177,000 гаруй ажилтантай Alphabet нь ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалтыг зах зээлээс татжээ.

### 2. MICROSOFT



Орлого: 211.9 тэрбум ам.доллар

Ажилчид: 221,000

Гүйцэтгэх захирал: Сатя Наделла

Үүсгэн байгуулагдсан: 1975

Microsoft-ын Windows, Office, Xbox зэрэг бүтээгдэхүүнүүд нь хэрэглэгчдийн өдөр тутмын амьдралд нэвт шингэж, бүтээмжийг нэмэгдүүлэх боломжийг хэрэглэгчдэд олгодог. Тус компани нь үүлэн тооцоолол, хиймэл оюун ухаан, тоглоомын салбарт асар их хөрөнгө оруулалт хийж инновацыг нэвтрүүлж байна. Үүлэн платформ Azure-ийн орлого 24 хувиар өсөж, 2023 оны эцэс гэхэд 33.7 тэрбум ам.долларт хүрсэн. Зах зээлийн үнэлгээ нь 3 тэрбум ам.доллараас давсан Microsoft дэлхийн хэмжээнд технологийн чиг хандлага, салбарын стандартыг бүрдүүлж зах зээлд ихээхэн нөлөө үзүүлж байгаа технологийн компани юм.

### 1. APPLE



Орлого: 383,285 тэрбум ам.доллар

Ажилчид: 164,000

Гүйцэтгэх захирал: Тим Күүк

Үүсгэн байгуулагдсан: 1976

Apple нь 2023 оны санхүүгийн жилд судалгаа, шинжилгээнд 29.92 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт оруулж, инновацын салбарын тэргүүн эгнээнд бичигдсэн хэвээр байна. Зах зээлийн үнэлгээ 2.5 тэрбум ам.доллараас давсан тус компани технологи, дизайны дэлхийн чиг хандлагыг удирдан чиглүүлж, зах зээлд чухал нөлөө үзүүлсээр байна. Хэдийгээр өрсөлдөөнийг үл харгалзан Apple-ийн хэрэглэгчдийн үнэнч байдал, iPhone, AirPods, macOS, iOS болон төрөл бүрийн үүлэн технологи зэрэг бүтээгдэхүүн, үйлчилгээний цогц экосистем нь технологийн салбарт тэргүүлэх байх суурийг эзэлдэг. Apple-ийн хувийн нууцлал, аюулгүй байдлын технологи нь дижитал харилцаанд өгөгдөл хамгаалахыг чухалчилдаг бөгөөд энэ нь хэрэглэгчдийн анхаарлыг татаж Apple сонгох томоохон хүчин зүйлийн нэг болдог.

Эх сурвалж: <https://fintechmagazine.com/top10>

## СУДЛААЧИЙН ИНДЭР

### МӨНГӨНИЙ ЗАХ ЗЭЭЛ БА ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

#### Гүйцэтгэсэн:

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Б.Батчимэг, СЗХ, ЗЗСХГ, Сэндбоксын албаны дарга,  
batchimeg\_b@frc.mn

Г.Анхзаяа, СЗХ, ЗЗСХГ, Сэндбоксын албаны мэргэжилтэн,  
ankhzaya\_g@frc.mn

О.Мичидмаа, СЗХ, ЗЗСХГ, Сэндбоксын албаны мэргэжилтэн,  
michidmaa\_o@frc.mn

#### ХУРААНГУЙ

Нэг жилээс богино хугацаат үнэт цаас, санхүүгийн хэрэгслүүд арилжаалагдах зах зээлийг мөнгөний зах зээл гэж нэрлэдэг бөгөөд санхүүгийн системд мөнгө болон хөрөнгийн зах зээл хоршин ажилласнаар зах зээл дэх нөөц хөрөнгө илүү үр ашигтайгаар, тасралтгүй эргэлдэх боломж бүрддэг. Монгол Улсын мөнгөний зах зээлд Төв банкнаас мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор арилжааны банкнуудад гаргасан хэрэгслүүд түгээмэл арилжаалагддаг хэдий ч банкнаас бусад санхүүгийн салбар болон санхүүгийн бус салбарын оролцогчдын хувьд мөнгөний захын хөгжил сул байсаар ирсэн. Харин санхүүгийн систем нь өндөр хөгжсөн улс орнуудын хувьд мөнгөний захын арилжааны идэвхжил өндөр бөгөөд мөнгөний захын төрөл бүрийн хэрэгслүүд голчлон биржийн бус зах зээлийн зарчмаар арилжаалагдаж байна. Сүүлийн жилүүдэд санхүүгийн салбарт эрчимтэй нэвтэрч буй технологийн дэвшлийг ашиглан улс орнууд үнэт цаас, санхүүгийн хэрэгслийн бүртгэл, хадгалалт, төлбөр тооцоог цогцоор нь шийдсэн цахим арилжааны платформыг хөгжүүлэх болсон бөгөөд эдгээр төрлийн платформууд дээр мөнгөний захын хэрэгсэл идэвхтэй арилжаалагдаж буй олон улсын туршлагууд нэмэгдсээр байна.

Түлхүүр үгс: богино хугацаат санхүүгийн хэрэгсэл, цахим арилжааны платформ, санхүүгийн систем

JEL ангилал: E44, G28, O38

#### УДИРТГАЛ

Энэхүү судалгаа нь мөнгөний зах зээлийн онцлог шинж чанар, ач холбогдол болон Монгол Улс болон олон улсын мөнгөний захын нөхцөл байдлыг судлах, санхүүгийн зах зээлийн хөгжлөөр тэргүүлэгч улс орнуудад мөнгөний захын арилжаа хэрхэн явагдаж, ямар хэлбэрээр зохицуулагдаж буйг судлах, үүнд үндэслэн Монгол Улсын зохицуулалтын орчинд мөнгөний зах зээлд холбогдох зохицуулалтыг хэрхэн хийж болох тухай судлахад чиглэсэн болно. Судалгааны дараах бүлгүүдэд мөнгөний зах зээлийн талаарх ойлголт, олон улсын болон Монгол улсын мөнгөний зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, мөнгөний зах зээлийн зохицуулалт улс орнуудад хэрхэн хэрэгжиж буй талаар болон холбогдох дүгнэлт, саналыг тусгасан болно.

## МӨНГӨНИЙ ЗАХ ЗЭЭЛ

### Мөнгөний зах зээл гэж юу вэ?

Мөнгөний зах зээл нь оролцогчид нэг жил ба түүнээс богино хугацааны өндөр хөрвөх чадвартай өрийн үнэт цаасыг зээлж, зээлэх боломжтой зохион байгуулалттай валютын зах зээл юм. Энэ нь засгийн газар, банкнууд болон бусад томоохон байгууллагуудад богино хугацааны мөнгөн гүйлгээний хэрэгцээгээ санхүүжүүлэхийн тулд богино хугацааны үнэт цаас зарах боломжийг олгодог. Мөнгөний зах зээл нь хувь хүн, хөрөнгө оруулагчдад эрсдэл багатай нөхцөлд бага хэмжээний хөрөнгө оруулалт хийх боломжийг олгодог. Түүнчлэн мөнгөний зах зээлийн санхүүгийн хэрэгслүүд нь бараг мөнгөтэй адил хөрвөх чадвар сайтай байдаг тул энэ зах зээлийг мөнгөний зах зээл гэж нэрлэдэг.

Мөнгөний зах зээл дээр арилжаалагдаж байгаа үнэт цаас нь ихэвчлэн хөнгөлөлттэй байдаг ба үнэт цаасыг нэрлэсэн үнээс нь бага үнээр хямдруулан худалддаг. Харин үнэт цаас эзэмшигчид төлбөрийг эргэн төлөхдөө нэрлэсэн үнээр хийдэг.

### Мөнгөний зах зээлийн онцлог, давуу тал

Мөнгөний зах зээлийн үнэт цааснуудын нэрлэсэн үнэ маш өндөр байдаг. Арилжаа нь ихэнхдээ биржийн бус зах зээл дээр хийгддэг. Төвлөрсөн нэг цэг буюу бирж дээр ихэнхдээ хийгддэггүй. Маш идэвхтэй хоёрдогч зах зээлтэй ба үүнийгээ дагаад хөрвөх чадвар өндөртэй байдаг ба мэдээллийн тэгш бус байдлыг бууруулдаг. Банкны хувьд татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн тодорхой хэсгийг хадгалж, үүнийг зээл хэлбэрээр бусдад олгох боломжгүй байдаг. Харин мөнгөний зах зээл дээр ийм хязгаарлалт байхгүй. Мөн банк нь хуулийн хязгаарлалт ихтэй бөгөөд санал болгож буй бүтээгдэхүүний хүүг өөрчлөхөд хүндрэлтэй байх тохиолдол үүсэж болно.

Томоохон байгууллагуудын хувьд богино хугацааны орох мөнгөн урсгал ба гарах мөнгөн урсгалыг хооронд нь тохируулах хүндрэлтэй байдаг. Хэрэв хүлээгдэж буй орох мөнгөн урсгал нь хүлээгдэж буй гарах мөнгөн урсгалаас хоцорч орж ирэхээр байгаа тохиолдолд корпорац, Засгийн газар нь мөнгөний зах зээл дээрээс богино хугацаатай санхүүжилт авч төлбөрийг барагдуулж болох юм. Ингэснээр хэсэг хугацааны дараа орж ирэх орлогоор тухайн зээлийн төлбөрийг барагдуулж болно. Богино хугацаагаар мөнгө

зээлдүүлэгч буюу мөнгөний шаардлага гарвал түүнийгээ хоёрдогч зах зээл дээр түргэн хугацаанд борлуулах боломжтой.

### Мөнгөний зах зээлийн оролцогчид

Мөнгөний зах зээлийн зээлдүүлэгчид: Байгууллагад богино хугацаанд илүүдэл мөнгө үүсэж болно. Үүнийг хэрэгцээ үүстэл богино хугацаатай хадгалах газар байгууллагын касс, мөнгөний зах зээл эсхүл банкны харилцах данс байж болдог. Мөнгөний зах зээлийн үнэт цаасанд хөрөнгө оруулснаар банкны харилцах дансны хүүгээс илүү өндөр өгөөж хүртэх, хөрөнгөө өсгөх боломжтой байдаг.

Мөнгөний зах зээлийн зээлдэгчид: Томоохон, нэр хүнд бүхий корпорац, байгууллага, Засгийн газрууд шаардлагатай богино хугацаат санхүүжилтийн эх үүсвэрээ банкны зээлийн хүүгээс бага хүүтэй татахад тусалдаг.

Брокер, дилерүүд: Брокерын пүүс, дилерүүд нь мөнгөний зах зээлийн хэрэгслийг худалдан авагч болон худалдагчдыг холбосноор мөнгөний зах зээл дэх гүйлгээг хөнгөвчилдөг.

### Бусад оролцогчид:

Сангийн яам, Төв банк, Арилжааны банкнууд, Бизнесийн байгууллагууд, Даатгалын компани, Мөнгөний зах зээлийн сан, Санхүүгийн байгууллагууд, Тэтгэврийн сан, Хувь хөрөнгө оруулагчид

### Мөнгөний зах зээлийн хэрэгслүүд

Мөнгөний зах зээлийн хэрэгслүүд нь аж ахуйн нэгжүүдэд богино хугацаанд мөнгө зээлэх, зээлэх хэрэгсэл болох богино хугацаатай, өндөр хөрвөх чадвартай санхүүгийн хэрэгсэл юм. Эдгээр хэрэгслүүд нь эрсдэл багатай, богино хугацаатай байдаг тул аюулгүй байдал, хөрвөх чадварыг эрэлхийлж буй хөрөнгө оруулагчдын сонирхлыг татдаг. Мөнгөний зах зээлийн санхүүгийн хэрэгслүүд хөрвөх чадвар өндөртэй байдаг.

- ◆ **Засгийн газрын үнэт цаас:** Засгийн газраас гаргадаг богино хугацаат буюу хэдхэн хоногоос нэг жил хүртэлх хугацаатай үнэт цаас юм. Тэд мөнгөний зах зээлийн хамгийн найдвартай хэрэгслүүдийн нэгт тооцогддог.
- ◆ **Арилжааны бичиг:** Корпорацууд болон санхүүгийн байгууллагуудаас гаргадаг богино хугацааны

баталгаагүй вексель юм. Ихэвчлэн хэдхэн хоногоос 270 хоног хүртэлх хугацаатай байдаг. Корпорацууд өөрсдийн богино хугацааны санхүүжилтийн хэрэгцээг хангахын тулд арилжааны бичиг ашигладаг.

- ◆ Хадгаламжийн сертификат (CD): Банк болон бусад санхүүгийн байгууллагуудаас санал болгож буй хугацаатай хадгаламж юм. Одоогийн байдлаар биет буюу цаасан хэлбэрээр гарж байгаа. Тогтоосон хугацаанд бэлэн мөнгө байршуулсны оронд тодорхой хэмжээний хүү төлөхийг зөвшөөрсөн вексел ба зах зээлийн нөхцөлд ихэвчлэн богино хугацаатай байдаг.
- ◆ Буцаан худалдан авах гэрээ (Repo): Repo хэлцлээр нэг тал үнэт цаасыг тодорхой өдөр, үнээр эргүүлэн худалдаж авах гэрээ байгуулан нөгөө талд худалддаг. Энэ нь ихэвчлэн засгийн газрын үнэт цаасыг хамарсан богино хугацааны барьцаатай зээлийн зохицуулалт юм.
- ◆ Банкирын акцепт (BA): Банкирын акцепт гэдэг нь зээлдэгчийн банканд хугацаа нь дууссаны дараа төлөх үүргийг хүлээн зөвшөөрч, банк дээр зурсан хугацаа юм.

БА нь олон улсын худалдааны санхүүжилтэд ихэвчлэн ашиглагддаг.

- ◆ Мөнгөний зах зээлийн хамтын сангууд (MMFs): Мөнгөний захын хамтын сангууд нь олон тооны хөрөнгө оруулагчдаас мөнгө цуглуулж, засгийн газрын үнэт цаас, арилжааны бичиг, хадгаламжийн сертификат зэрэг богино хугацаат үнэт цаасны төрөлжсөн багцад хөрөнгө оруулалт хийдэг.
- ◆ Богино хугацаат хотын үнэт цаас: Төрийн болон орон нутгийн засаг захиргаанаас гаргасан эдгээр үнэт цаасанд богино хугацаат үнэт цаас болон санхүүгийн хэрэгцээгээ хангах бусад өрийн хэрэгслүүд багтана.
- ◆ Евро долларын хадгаламж: Евро долларын хадгаламж нь АНУ-аас бусад банкнуудад хадгалагдаж буй ам.доллараар илэрхийлэгдсэн хадгаламж юм. Тэдгээрийг ихэвчлэн олон улсын худалдаа, санхүүгийн салбарт ашигладаг.
- ◆ Богино хугацаат компанийн бонд: Зарим компаниуд ойрын хэрэгцээгээ хангах зорилгоор богино хугацааны бонд гаргадаг. Эдгээр бонд нь ихэвчлэн нэгээс таван жилийн хугацаатай байдаг.

## ОЛОН УЛСЫН МӨНГӨНИЙ ЗАХ ЗЭЭЛ

Дэлхийн мөнгөний зах зээл нь 24 цагийн турш ажилладаг. Лондон, Нью-Йорк, Франкфурт, Токио, Хонконг, Сингапур зэрэг дэлхийн санхүүгийн төвүүд нь газар зүйн байршлын хувьд нээлттэй ажиллаж байх боломжийг олгодог.

### Америкийн Нэгдсэн Улсын мөнгөний зах зээл

АНУ-ын мөнгөний зах зээл нь санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, богино хугацааны санхүүжилтийн хэрэгцээг хангах, зээлийн хүүд үзүүлэх нөлөөгөөр эдийн засгийн өргөн хүрээний нөхцөл байдалд нөлөөлөхөд маш чухал юм. Холбооны нөөцийн сан нь мөнгөний бодлогын зорилгодоо хүрэхийн тулд мөнгөний зах зээлийг хянах, удирдахад гол үүрэг гүйцэтгэдэг.

Мөнгөний зах зээл нь Холбооны нөөцийн сангаас гадна АНУ-ын олон төрлийн санхүүгийн байгууллагуудын дунд ажилладаг. Санхүүгийн байгууллагууд, тэр дундаа

арилжааны банкнууд, хөрөнгө оруулалтын банкнууд, мөнгөний зах зээлийн хамтын сангууд болон бусад байгууллагууд мөнгөний зах зээлд идэвхтэй оролцдог. Мөнгөний зах зээл дээрх гүйлгээ нь ихэвчлэн төвлөрсөн бирж дээр бус талуудын хооронд шууд явагддаг бөгөөд санхүүгийн байгууллагууд хоорондоо шууд болон брокер, дилерээр дамжуулан арилжаа хийж болдог. Мөнгөний зах зээл нь гүйлгээний хувьд уян хатан байдал, тохируулга хийх боломжийг олгодог.

### АНУ-ын мөнгөний зах зээлийн голлох хэрэгслүүд:

Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ), Арилжааны баримт бичиг (CP), Буцаан худалдан авах гэрээ (Repo), Мөнгөний зах зээлийн хамтын сангууд (MMFs).

### Герман Улсын мөнгөний зах зээл

Дэлхийн 2-р дайны дараагаас Баруун Германы нутаг

дэвсгэрт мөнгөний зах зээл хүчтэй хөгжиж эхэлсэн. Мөнгөний зах зээлийн гүйлгээ нь ихэвчлэн банк хоорондын зээлээр хязгаарлагддаг. Түүнчлэн даатгалын компаниуд болон бусад банк бус хөрөнгө оруулагчид нь богино хугацаат сангийн чухал зээлдүүлэгчид байдаг. Герман улсын банкнууд хоорондоо богино хугацаат засгийн газрын үнэт цаасны арилжаанд дасаагүй бөгөөд үнэт цаасыг хугацаа дуустал нь эзэмшиж эсхүл төв банканд худалдан авах ханшаар нь зардаг тул мөнгөний зах зээл төдийлөн хөгжөөгүй байна.

Арилжааны бичиг/Commercial paper/-ийг банкнуудын хооронд арилжаалах зах зээлд тодорхой ач холбогдолтой бөгөөд, ялангуяа энэхүү арилжаа нь зах зээлийн хүнд нөхцөлд үе үе явагддаг. Түүнчлэн Бундесбанкаар дамжуулан хэд хэдэн төрлийн арилжааны цаасыг дахин тооцоолох тухай цогц зохицуулалтыг гаргасан. Европын Төв банк (ECB) нь Германыг багтаасан Евро бүсийн мөнгөний бодлогыг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Санхүүгийн зах зээл, түүний дотор мөнгөний зах зээл нь Герман, Европын эрх баригчдын зохицуулалтад захирагддаг. Европын Төв банкны бодлого нь Евро бүсийн нийт мөнгөний зах зээлд нөлөөлдөг.

### **Герман Улсын мөнгөний зах зээлийн голлох хэрэгслүүд:**

Төрийн сангийн үнэт цаас (Bubills), Арилжааны бичиг, Буцаан худалдан авах гэрээ (Repo)

### **Франц Улсын мөнгөний зах зээл**

Францын мөнгөний зах зээл нэлээд сайн хөгжсөн бөгөөд мөнгөн тэмдэгт нь мөнгөний нийлүүлэлтэд чухал үүрэг гүйцэтгэдэг ба мөнгөний нийлүүлэлт хязгаарлагдмал байдаг учир зохицуулалтын дагуу эдийн засгийн санхүүгийн бус хувийн хэвшлийг зах зээл дээр ажиллуулахгүй гэж заасан байдаг. Банкнууд, түүнчлэн санхүүгийн салбарт ажилладаг цөөн хэдэн төрийн болон хагас төрийн байгууллагууд, зуучлагчид/брокер/, discount house зэрэг нь зах зээлийг бүрдүүлдэг. Гүйлгээ нь арилжааны бичиг болон засгийн газрын үнэт цаасаар хийгддэг. Төв банк нь банкнууд болон бусад санхүүгийн байгууллагуудын эзэмшиж буй бүх засгийн газрын үнэт цаасны нягтлан бодох бүртгэлийн тусгай системийг хөтөлдөг бөгөөд үүний дагуу эдгээр үнэт цаасыг бодит гэрчилгээгээр төлөөлдөггүй, харин Төв банк нь төрийн

сангийн тусгай дансны бичилтээр төлөөлдөг.

Орон нутгийн мөнгөний зах зээл дэх тогтворгүй байдлыг намжаахад чиглэгдсэн Төв банкны нээлттэй зах зээлийн үйл ажиллагаа сүүлийн жилүүдэд чухал болж байна. Хүсээгүй хөрөнгийн урсгалаас урьдчилан сэргийлэхийн тулд дотоодын мөнгөний зах зээлийн ханшийг олон улсын ханштай нийцүүлэх үүднээс нээлттэй зах зээлийн гүйлгээг хийдэг. Төв банкнаас мөнгөний зах зээлээр дамжуулан мөнгөний нөхцөл байдалд нөлөөлөх боломж нь засгийн газрын богино хугацаат эх үүсвэрийн томоохон хэрэгцээ, засгийн газрын урт хугацааны зээлийн зах зээл бүрдээгүй байгаа зэргээр хязгаарлагддаг.

### **Франц Улсын мөнгөний зах зээлийн голлох хэрэгслүүд:**

Treasury Bills (BTFs), Арилжааны бичиг (Commercial Paper), Буцаан худалдан авах гэрээ (Repo)

Францад хөрөнгө оруулагчид янз бүрийн санхүүгийн хэрэгсэл, байгууллагуудаар дамжуулан мөнгөний зах зээлд оролцох боломжтой. Франц дахь мөнгөний зах зээл нь бусад улс орны нэгэн адил хувь хүмүүс, корпорацууд, институтын хөрөнгө оруулагчдад богино хугацааны хөрөнгө оруулалтын боломжийг санал болгодог. Мөнгөний зах зээлийн электрон арилжааны платформууд болон брокерын үйлчилгээнүүд нь мөнгөний зах зээлийн янз бүрийн хэрэгслүүдэд шууд нэвтрэх боломжийг олгож, хөрөнгө оруулагчдад богино хугацааны үнэт цаас худалдан авах, худалдах боломжийг олгодог.

### **Хөгжиж буй орнуудын мөнгөний зах зээл**

Хөгжиж буй орнуудын мөнгөний зах зээл нь санхүүгийн ерөнхий системийн чухал бүрэлдэхүүн хэсэг болж, богино хугацааны зээл, зээлийн үйл ажиллагааг хөнгөвчилдөг.

Хөгжиж буй орнуудын хувьд сайн хөгжсөн мөнгөний зах зээл нь өндөр орлоготой цөөн тооны оронд л байдаг. Бусад улс оронд мөнгөний зах зээл жижиг, нэгдмэл байдал муутай, ихэнх тохиолдолд бараг байдаггүй. Хөгжиж буй орнуудын мөнгөний зах зээл нь хөгжингүй эдийн засагтай орнуудынхтай ижил нийтлэг шинж чанартай байдаг ч эдийн засгийн нөхцөл байдал,

зохицуулалтын хүрээ, зах зээлийн байдлаас шалтгаалж өөр өөр байж болно. Бага орлоготой ихэнх орнуудад мөнгөний зах зээл ямар ч үүрэг гүйцэтгэдэггүй ба санхүүгийн систем хязгаарлагдмал байдаг. Социалист тогтолцоотой орнуудаас бусад хөгжиж буй ихэнх улс орнууд богино хугацаат засгийн газрын үнэт цаасыг борлуулах боломжоор хангах зорилгоор мөнгөний зах зээлийг дэмжих бодлого баримталдаг. Үүний зэрэгцээ

эдгээр засгийн газруудын ихэнх нь засгийн газрын өрийн өртгийг бууруулах, хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор бага хүүтэй мөнгөний бодлого баримталдаг.

### Хөгжиж буй орнуудын мөнгөний зах зээлийн голлох хэрэгслүүд:

Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ), Арилжааны бичиг (CP), Хадгаламжийн гэрчилгээ (CD), Буцаан худалдан авах гэрээ (РЕПО).

## МОНГОЛ УЛСЫН МӨНГӨНИЙ ЗАХ ЗЭЭЛ

Монгол улсад Төв банкны зохицуулалттай мөнгөний зах зээл идэвхтэй ажиллан хөгжиж ирсэн бөгөөд Төв банк нь мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор дараах хэрэгслүүдийг ашиглаж мөнгөний зах зээлд оролцдог. Үүнд:

**Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ):** Монгол Улсын Засгийн газраас хөрөнгө босгох зорилгоор гаргасан богино хугацаат өрийн үнэт цаас. ЗГҮЦ нь ихэвчлэн хэдэн өдрөөс нэг жил хүртэлх хугацаатай байдаг. Засгийн газрын санхүүгийн удирдлагыг сайжруулах, мөнгөний бодлогын арга хэрэгслийг нэмэгдүүлэх зорилгоор 2012 оны 10 дугаар сараас эхлэн

Засгийн газар Монголбанкаар дамжуулан Засгийн газрын үнэт цаасыг анхдагч зах зээл дээр гарган, арилжаалсан. ЗГҮЦ нь санхүүгийн зах зээл дэх хамгийн эрсдэл багатай хөрөнгө оруулалтын хэрэгсэл бөгөөд хүүгийн орлого нь албан татвараас чөлөөлөгддөг давуу талтай байна.

**Төв банкны үнэт цаас (ТБҮЦ):** Монголбанкны мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл юм. Иймд ТБҮЦ-ны анхдагч захын арилжаанд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа банкнууд оролцох боломжтой бөгөөд арилжааны төрлийг Монголбанкнаас арилжаа хийх бүрд зарладаг.

Зураг. Нээлттэй захын үйл ажиллагаа



**Репо арилжаа:** Төв банкны репо арилжаа нь нээлттэй зах зээлийн хэрэгслийн нэг бөгөөд Монголбанкнаас банкны эзэмшиж буй үнэт цаасыг хугацааны эцэст урьдчилан тохиролцсон үнээр буцаан худалдах нөхцөлтэй худалдан авах замаар банкны системд нөөц нийлүүлэх хэрэгсэл юм. /Монголбанкнаас 2015 оноос хойш нэг долоо хоног хүртэлх хугацаатай репо арилжаа зохион байгуулаагүй байна./

Банк хоорондын зах дээрх богино хугацааны нөөцийн хэлбэлзлийг бууруулах, богино хугацаатай хүүг удирдах зорилгоор нөөц нийлүүлэх шаардлагатай үед Төв банк нөөцийн таамаглалд үндэслэн репо арилжаа зарладаг. Гэхдээ Монгол улсын БХЗ-ын бүтцийн илүүдэл нөөцийг харгалзан уг хэрэгслийг одоогоор ашиглах шаардлага үүсэхгүй байна. Журмын дагуу 7 хүртэл хоногийн хугацаатай репо арилжааг тогтмол хүүтэй, хэмжээ хязгаарлаагүй эсхүл хүүгийн доод хязгаартай, хэмжээ хязгаарлаж, хүүгээр өрсөлдүүлэх хэлбэрээр зохион байгуулах боломжтой.

**Овернаит арилжаа:** Овернаит арилжаа гэдэг нь арилжааны нэг өдрийн хаалт болон дараагийн өдрийн нээлтийн хооронд ердийн арилжааны цагаас гадуур санхүүгийн хэрэгслийг худалдан авах, зарахыг хэлнэ. Энэ нь өргөн хүрээний мөнгөний зах зээлийн дэд хэсэг юм.

**Хадгаламжийн сертификат:** Энэ нь хугацаатай хадгаламжаас өндөр хүү төлдөг хатуу нөхцөлтэй бүтээгдэхүүний нэг юм. Өөрөөр хэлбэл, хадгаламжийн хугацааны дундуур орлого хийх ба хугацаанаас өмнө

цуцлах боломжгүй байдаг. Харин мөнгөний хэрэгцээ гарсан бол бусдад шилжүүлэх, зарах, бэлэглэх замаар бэлэн мөнгө болгож болдог.

**Төв банкнаас гадуурх мөнгөний зах зээл:** Бусад хөгжиж буй орнуудын адилаар манай улсын зах зээлд мөнгөний зах зээл төдийлөн сайн хөгжөөгүй бөгөөд Төв банкнаас мөнгөний бодлогын зорилгоор арилжаалдаг мөнгөний захын хэрэгслүүд арилжааны банкнуудын хооронд голчлон арилжаалагдсаар ирсэн. Харин 2021 оны 12 дугаар сард банк бус санхүүгийн байгууллагуудын богино хугацаат санхүүжилтийн хэрэгцээ, шаардлагыг хангах, богино хугацаат нөөцийг оновчтой удирдах зорилгоор банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн багцаар баталгаажсан репо хэлцлийн зуучлалын үйлчилгээг “Мони Маркет Фанд” ХХК нэвтрүүлсэн бөгөөд 2021.12.17-ны өдөр сэндрокс орчинд орон тус үйлчилгээг сэндроксын орчинд туршиж эхэлсэн. Тус компани нь платформоор дамжуулан репо хэлцлийн хүсэлт хүлээн авах, хэлцлийн дагуу худалдагч болон худалдан авагч хоёр талыг холбох зуучлалын үйлчилгээг үзүүлж буй. Одоогийн бизнес загварын дагуу банк бус санхүүгийн байгууллагуудын репо арилжаа нь платформоор дамжуулан худалдах, худалдан авах хүсэлт өгч, хэлцэл биелсэн тохиолдолд оролцогчдын гүйлгээ платформоос гадуур буюу хэлцлийн оролцогчдын дунд шууд хийгддэг.

“Мони Маркет Фанд ХХК”-ийн явуулж буй үйл ажиллагааны ерөнхий төлөв байдлыг илэрхийлэх статистик үзүүлэлтүүдийг доорх хүснэгтэд харууллаа.


Зураг. “Мони Маркет Фанд” ХХК-аар дамжин арилжаалагдаж буй репо хэрэгслийн статистик

Хугацаа	Зээлдүүлэгчийн тоо	Зээлдэгчийн тоо	Арилжааны тоо	Арилжааны дүн	Дундаж хүү	Зээлийн дундаж хугацаа
1 сар	7	8	30	6,960,000,000	16.83	27
2 сар	16	13	63	12,330,000,000	17.42	39
3 сар	12	14	56	10,830,000,000	17.27	28
4 сар	11	10	31	5,860,000,000	16.76	25
5 сар	10	11	37	7,430,000,000	16.73	35
6 сар	13	14	49	10,960,000,000	17.84	33
7 сар	9	11	39	9,610,000,000	18.6	34
8 сар	10	16	57	14,220,000,000	18.2	38
9 сар	12	14	44	7,010,000,000	18.87	32
<b>Нийт</b>	-	-	<b>406</b>	<b>85,210,000,000</b>	<b>18.48</b>	<b>32</b>

Мони Маркет Фанд” ХХК нь хадгаламжийн сертификатын бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд шинээх нэвтрүүлэхээр зорьж буй. Арилжааны банкнууд хадгаламжийн нэг төрлийн бүтээгдэхүүн болох хадгаламжийн сертификатыг одоогийн байдлаар биет буюу цаасан хэлбэрээр гаргаж байна. Энэ нь тус бүтээгдэхүүнийг бүртгэх нэгдсэн систем байргүй байгаатай холбоотой ба бидний системд тус төрлийн үнэт цаасыг бүртгэх боломжтой болгосноор цахим хэлбэрээр иргэд, аж ахуйн нэгжүүдээс тогтвортой эх үүсвэр татан төвлөрүүлэх боломжтой болохоор байна хэмээн үзсэн.

Ийнхүү хадгаламжийн сертификат нь платформоор дамжуулан 2023 оны 9 дүгээр сарын 6–ны өдрөөс эхлэн арилжаалагдаж эхэлсэн. Үүнээс хойш 2023 оны 11 сарын 30–ны байдлаар нийт 49.4 сая төгрөгийн Хадгаламжийн сертификат арилжаалагдсан байна.

Зураг. Мөнгөний захын хүүгийн түвшин ба арилжааны дүн, репо зээлийн хугацаагаар



# ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САН ГЭЖ ЮУ ВЭ?



Монгол банк болон зээлийн  
мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч  
этгээдийн эзэмшиж байгаа  
зээлдэгчийн мэдээлэл.



## ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ЗОРИЛГО



- Иргэд, аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн хариуцлагыг нэмэгдүүлэх,
- Зээлийн эрсдлээс урьдчилан сэргийлэх,
- Чанаргүй зээлийн хэмжээг бууруулах



Банк, санхүүгийн байгууллагын зээлийн судалгааны зардлыг бууруулах

## ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САНД МЭДЭЭЛЭЛ НИЙЛҮҮЛЭГЧ



Банк, ББСБ, ХЗХ



Үүрэн холбооны операторууд



Санхүүгийн түрээсийн компани



Төрийн байгууллагууд




Гэрээний дагуу хуулийн этгээдүүд

## ЗЭЭЛДЭГЧИЙН ЗЭЭЛИЙН ТҮҮХ, ТҮҮНИЙ ҮР ДАГАВАР



### ЗЭЭЛ ТӨЛӨГДӨӨГҮЙ ХУГАЦААНААС ХАМААРЧ ДАРААХ БАЙДЛААР АНГИЛДАНА:



### Нэмэлт мэдээлэл



- ❑ Зээлийн **лавлагааг** харилцдаг банк, санхүүгийн байгууллагаас өөрийн биеэр бичиг баримттай очиж авна.
- ❑ Зээлийн мэдээллийн санд тухайн зээлдэгчийн **сүүлийн 10 жилийн** зээл, төлбөрийн болон үлдэгдэлтэй зээлийн мэдээлэл хадгалагддаг.
- ❑ Зээлийн мэдээллийн лавлагаанд **ташаа мэдээлэл** орсон бол зээл олгосон байгууллагыг үнэн зөв болгохыг шаардах эрхтэй.
- ❑ Мэдээлэл нийлүүлэгч зээл, төлбөрийн мэдээлэл, нэмэлт өөрчлөлтийг **ажлын гурван өдрийн дотор** зээлийн мэдээллийн санд нийлүүлдэг.




Зээлийн мэдээллийн тухай  
хууль



## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### ЕВРОПЫН ТӨВ БАНК 5 ЖИЛИЙН ДАРАА АНХ УДАА БОДЛОГЫН ХҮҮГЭЭ БУУРУУЛЛАА.

#### ECB Inflation Forecast



Европын төв банк бодлогын хүүгээ 25 нэгжээр бууруулж 4 хувиас 3.75 хувьд хүргэлээ. Энэ нь сүүлийн 5 жилийн хугацаанд анх удаа бодлогын хүүгээ бууруулсан тохиолдол байв.

Мөн Европын төв банк 2024 оны инфляцыг 2.5 хувьтай байна гэж таамаглаж байгаа бөгөөд инфляц 2025 онд 2.2, 2026 онд 1.9 хувьд хүрж буурах хандлагатай байгааг мэдэгдлээ.

Евро бүсийн эдийн засаг 2025 онд 1.4, 2026 онд 1.6 хувиар өснө хэмээн таамаглаж буй бөгөөд төв банкнаас дараагийн шийдвэрээ гаргахдаа өрийн дарамт хэрэглэгчдэд дарамт үзүүлж байгаа нөхцөлийг харгалзана гэдгээ мэдэгдлээ.

Европын төв банк бодлогын хүүгээ бууруулах шийдвэр гаргасны дараа Европын хувьцааны зах зээл өндөр өсөлтийг үзүүлж "Euro Stoxx 600" индекс 0.7 хувиар өсөн 5 дугаар сарын дээд түвшинд хүрсэн бөгөөд эрүүл мэндийн салбар, мөн Европын голлох томоохон арилжааны банкнууд өсөлттэй, үл хөдлөх хөрөнгийн салбар, нийтийн аж ахуйн салбар уналтыг үзүүлжээ.

Эх сурвалж: [www.bloomberg.com](http://www.bloomberg.com)

### ЕВРОПЫН НҮҮРСТӨРӨГЧИЙН ЗАХ ЗЭЭЛ /КАРБОН МАРКЕТ/ ГЭНЭТИЙН ЭРГЭЛТ ХИЙЛЭЭ.

Он гарснаар Европын нүүрстөрөгчийн зах зээл бууралтыг үзүүлсэн. Европын орнуудад нүүрсээр ажилладаг цахилгаан станц болон ган үйлдвэрлэгчид нүүрстөрөгчийн татвар тонн тутамд 57 евро хүржээ. 2023 онд салхи, нараар



ажилладаг цахилгаан станцууд Европын холбооны хэмжээнд хамгийн их цахилгаан үйлдвэрлэсэн ба байгалийн хийн нийлүүлэлт багсаж, түлшний үнэ өсөхөд эрчим хүчний хямрал нөлөөлжээ.

Эх сурвалж: [www.bloomberg.com](http://www.bloomberg.com)

### NASDAQ ИНДЕКС ТАВ ДАХЬ УДААГАА ДЭЭД АМЖИЛТ ТОГТООЛОО.

НЬЮ ЙОРК, 6-р сарын 14 – Баасан гарагт Adobe болон бусад технологийн компанийн хувьцааны ханш өсөж Nasdaq индекс 5 дахь дээд амжилтаа тогтоосон бол S&P 500 индекс болон Dow Jones индексүүд бага зэрэг буурчээ.

S&P 500 индекс дөрвөн өдрийн турш дараалан өссөн ч долоо хоногийн дундаж 1 хувиар өссөн байна.

S&P 500 технологийн салбар (.SPLRCT) шинэ амжилт тогтоож 0.5 хувиар өссөн. Харилцаа холбооны үйлчилгээний салбар 0.6 хувиар өсөж салбар хоорондын өсөлтийг тэргүүлжээ. Adobe (ADBE.O) компанийн хиймэл оюун ухаанаар ажилладаг программ хангамжийн эрэлт хэрэгцээ нэмэгдэж жилийн орлого нэмэгдэх төлөв үзүүлсний дараа хувьцаанууд 14.5 хувиар өссөн байна.

Dow Jones Industrial Average (.DJI) 7.94 нэгж буюу 0.15 хувиар буурч 38,589.16 нэгжид хүрчээ. S&P 500 (.SPX) индекс 2.14 нэгж буюу 0.04 хувиар буурч 5,431.6 нэгжид, Nasdaq Composite (.IXIC) индекс 21.32 нэгж буюу 0.12 хувиар нэмэгдэж, 17,688.88 нэгжид хүрсэн байна. Долоо хоногийн турш Dow индекс 0.5 хувиар буурч, S&P 500 1.6 хувиар, Nasdaq 3.2 хувиар өссөн байна.

Эх сурвалж: [www.reuters.com](http://www.reuters.com)

## ХЯТАДЫН БАНК БОДЛОГЫН ХҮҮГЭЭ ХЭВЭЭР ҮЛДЭЭВ



ШАНХАЙ/СИНГАПУР, 6-р сарын 17-ны өдөр Хятадын төв банкнаас бодлогын хүүгээ хэвээр үлдээх шийдвэр гаргалаа. Тухайлбал, Хятадын төв банк бодлогын хүүгээ 2.5 хувьд хэвээр үлдээсэн ба хөрвөх чадварын эрсдэлээс сэргийлэх зорилгоор банкны системээс цэвэр 55 тэрбум юань буюу 7.6 тэрбум ам.доллар татжээ. Хятадын хэрэглээний үнийн индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.3 хувиар өссөн бөгөөд аялал жуулчлалын салбарын эрэлт нэмэгдэж байгаатай холбоотой үйлчилгээний өртөг нэмэгдсэн бөгөөд хэрэглээний үнэ өсөхөд бензиний үнийн өсөлт нөлөөлсөн байна.

Эх сурвалж: [www.cnbc.com](http://www.cnbc.com)

## HYUNDAI-ИЙН ЭНЭТХЭГ УЛСАД ХИЙСЭН IPO НЬ ТУС УЛСЫН ХАМГИЙН ТОМ НЬ БАЙЖ МАГАДГҮЙ



ШИНЭ ДЕЛИ, 6-р сарын 15 – Hyundai Motor's компани Энэтхэг улсын Мумбай дахь хөрөнгийн биржид

бүртгүүлэхээр зохицуулагч байгууллагаас зөвшөөрөл хүссэн бөгөөд Өмнөд Солонгосын толгой компанийн хувьцааны 17.5 хүртэлх хувийг арилжихаар болжээ. IPO хийснээр 2003 онд Maruti Suzuki компани хувьцаагаа гаргаснаас хойш хорин жилийн дараа Hyundai Motor's компани олон нийтэд нээлттэй болсон анхны автомашин үйлдвэрлэгч компани болох юм.

Hyundai нь Энэтхэг улсад хоёр үйлдвэртэй, 5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийж, ирэх арван жилд дахин 4 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөөтэй байгаа бөгөөд, Энэтхэг улсын зах зээлийн өсөлт авчрах чухал зах зээл гэж үздэг. Хятад, АНУ-ын дараа ордог дэлхийн хамгийн том автомашины зах зээл нь тус компанийн дэлхийн хэмжээнд гурав дахь том орлогын эх үүсвэр болох юм.

Hyundai компанийн хувьцааны танилцуулгад анхдагч зах зээлийн үнэ болон компанийн үнэлгээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөөгүй ч эх сурвалжийн мэдээлснээр Hyundai 2.5–3 тэрбум ам.долларыг 30 тэрбум ам.долларт хүргэхээр төлөвлөж байгаа ажээ.

Эх сурвалж: [www.bloomberg.com](http://www.bloomberg.com)

# ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2024 оны 06 дугаар сарын 13-ны өдөр

S&P 500 /<sup>^</sup>GSPC/

**5,421.03** +45.71 (+0.85%)



Nikkei 225 /<sup>^</sup>N225/

**38,955.59** +64.65 (+0.16%)



FTSE 100 /<sup>^</sup>FTSE/

**8,215.48** +67.67 (+0.83%)



NASDAQ Composite (<sup>^</sup>IXIC)

**17,608.44** +264.89 (+1.53%)



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC\_of\_Mongolia

ШУДАРГА ЕС-ХӨГЖИЛ ДЭВШИЛД

**110**

ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ УТАС  
/үнэ төлбөргүй/

АВАГЧ

ХИНА СУУТАН

АШИГ СОЁРЛАЛЫН ЗОРИУЛ

АВИАТАЙР ТӨМӨРХ ГАЗАР